



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг



Empowered lives.  
Resilient nations.

*Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарийн хөгжлийн агентлаг*

## **“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл**

# **2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2017 оны 01 дүгээр сарын 01-ээс 12 дугаар сарын 31

2017 оны 12 дугаар сар  
Улаанбаатар хот

## ТӨСЛИЙН ТУХАЙ

Тайлангийн огноо:	2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Төслийн дугаар	МОН/17/101
Төслийн нэр:	“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь”
Төсөл хэрэгжиж эхэлсэн огноо:	2017 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр
Төсөл хэрэгжиж дуусах огноо:	2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Хэрэгжүүлэгч:	Улсын Их Хурлын Тамгын газар
Төслийн талууд:	Монгол Улс дахь НҮБ, УИХ-ын Тамгын газар
Төслийн төсөв (нийт):	3,800,000 ам.д
Гол эх үүсвэр: Бусад эх үүсвэр:	
Донор 1	ШХА                    3,300,000 ам.дол
Донор 2	НҮБХХ                500,000 ам.дол
<p>НҮБХТХ, НҮБХХ-ийн улс орны хөтөлбөрийн холбогдох үр дүн: 2021 гэхэд засаглалын байгууллагууд залуучуудын үр нөлөөтэй оролцоог хангаж, ядуу, эмзэг бүлгийн эрхийг хамгаалан, иргэдийн өмнө хүлээх хариуцлага дээшилнэ.</p> <p>Төслийн үр дүн:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нутгийн удирдлагын эрх зүйн орчин сайжирсан байна</li> <li>2. ИТХ-ын зохион байгуулалтын чадавх сайжирсан байна</li> <li>3. Сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизм бий болсон байна.</li> <li>4. УИХ-ын Тамгын газрын Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх чадавх дээшилсэн байна</li> </ol>	
2017 оны төсөв	<b>1.120.000 ам.дол</b>
2017 оны 12 дугаар сарын 31-ний гүйцэтгэл	<b>1,029,500 ам.дол</b>
Гүйцэтгэл %	<b>92%</b>

## **ҮГИЙН ТОВЧЛОЛ**

УИХ	Улсын Их Хурал
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗЗНДНТУТХ	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МБСҮХ	Монголын баг, сумдын үндэсний холбоо
МНУН	Монголын нутгийн удирдлагын нийгэмлэг
МНУХ	Монголын нутгийн удирдлагын холбоо
НӨУБ	Нутгийн өөрөө удирдах байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ШХА	Швейцарийн хөгжлийн агентлаг
ОНХХ	Орон нутгийн хөгжлийн хүрээлэн
ТББ	Төрийн бус байгууллага

## Агуулга:

<b>ҮР ДҮН 1. НУТГИЙН УДИРДЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН САЙЖИРСАН БАЙХ.....</b>	<b>5</b>
➢ Нутгийн удирдлагын талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулахад дэмжлэг үзүүлэх .....	5
➢ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах холбогдох нэмэлт өөрчлөлт, нутгийн удирдлагын эрх зүйн тулгамдсан асуудлаар бүсчилсэн, сэдэвчилсэн хэлэлцүүлэг зохион байгуулах.....	6
<b>ҮР ДҮН 2. ИТХ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧАДАВХ САЙЖИРСАН БАЙХ.....</b>	<b>6</b>
➢ ИТХ-ын жишиг дэг боловсруулах, батлуулах .....	6
➢ Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн гарын авлага боловсруулах, ИТХ-ын үйл ажиллагаанд нэвтрүүлэх.....	7
➢ ИТХ-ын хяналт, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх сайн туршлагыг хөхиүлэн дэмжих зорилгоор ИТХ-д тэтгэлэг олгох.....	8
➢ ИТХ-ын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор төрийн бус байгууллагад тэтгэлэг олгох.....	11
➢ www.khural.mn цахим хуудасны хөтлөлт, хөгжүүлэлт .....	12
<b>ҮР ДҮН 3. ОРОН НУТГИЙН СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙНГЫН МЕХАНИЗМТАЙ БОЛОХ .....</b>	<b>15</b>
➢ Бүх шатны ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт .....	15
➢ Багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зориулсан суурь сургалт:.....	20
➢ ИТХ-ын Төлөөлөгчдийн манлайлын сургалт .....	25
➢ Үндэсний сургагч багш нарын сүлжээг дэмжих, хөгжүүлэх.....	29
➢ Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагыг шинэчлэх .....	33
➢ Төслийн үр дүнгийн тогтвортой байдлын төлөвлөгөө боловсруулах, ШХА-ын төслүүдтэй хамтран ажиллах үйл ажиллагаа .....	33
<b>ҮР ДҮН 4. СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ.....</b>	<b>34</b>
➢ УИХ-ын Тамгын газрын ажилтнуудыг хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, төслийн үр нөлөөг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалыг хэрэглэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр гадаад улсад сургалтад хамруулан сургагч багшаар бэлтгэх, ажилтнуудад сургалт зохион байгуулах .....	34
➢ УИХ-ын Тамгын газрын хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чадавхыг сайжруулах зорилгоор гадаад улсын туршлага судлах .....	36
➢ Холбогдох байнгын хорооноос хуулийн төслөөр нийтийн сонсгол зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.....	37
➢ УИХ-ын Тамгын газрын хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чадавхыг бэхжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх .....	37
<b>ДҮГНЭЛТ.....</b>	<b>37</b>

## ҮР ДҮН 1. НУТГИЙН УДИРДЛАГЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН САЙЖИРСАН БАЙХ

### ➤ Нутгийн удирдлагын талаарх эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулахад дэмжлэг үзүүлэх

Төслийн баримт бичигт Төрийн байгуулалтын Байнгын хороо, Нутгийн удирдлагын дэд хорооноос Монгол Улсын нутгийн удирдлагын тогтолцоонд шинэчлэл хийх үзэл баримтлал боловсруулах, харьцуулсан дүн шинжилгээнд тулгуурласан шинэчлэлийн хувилбарууд гаргах, бүсийн болон үндэсний чуулган, цахим хэлэлцүүлэг хийх зэргээр үзэл баримтлалын талаар харилцан ойлголцол, зөвшилцөл бий болгоход төслөөс дэмжлэг үзүүлэхээр заасан.

Энэ хүрээнд экспертүүдийн цуврал хэлэлцүүлэг 5 удаа зохион байгуулав. Хэлэлцүүлгийн зорилго нь нутгийн удирдлагын тодорхой асуудлаар эрдэмтэн судлаачдын дунд онол, практикийн чөлөөт мэтгэлцээн өрнүүлэх, харилцан санал бодлоо солилцох, мэдлэгээ хуваалцах, нэгдсэн ойлголт бий болгох, энэ чиглэлээр цаашид судалгаа, шинжилгээний ажил хийх сэдэв болон судалгааны чадавх бий болгох хэрэгцээ, шаардлагыг тодруулах, улмаар судлаачдын байр суурийг шийдвэр гаргагчдад хүргэх явдал байв. Хэлэлцүүлэгт МУИС, Удирдлагын академи, Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төв, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн багш, эрдэмтэн судлаач нар, төрийн бус байгууллага болон нутгийн удирдлагын байгууллагын төлөөлөл, УИХ-ын зарим гишүүд оролцлоо. Хэлэлцүүлгийг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хамрах хүрээ, зохицуулах харилцаа, төрийн болон орон нутгийн чиг үүргийн хуваарилалт, засаг захиргааны хуваарь, хотын статус сэдвээр явууллаа.

Тус хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, эрх зүйн харьцуулсан судалгаанд үндэслэн хуулийн төсөл боловсруулахад тодорхой хувилбар бүхий санал, зөвлөмж болон холбогдох бусад хуулийг хамарсан нутгийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох үзэл баримтлал боловсруулах зөвлөх үйлчилгээг “Хууль судлалын төв” ТББ үзүүлж байна.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд “Тосгоны эрх зүйн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай хамтран Сэлэнгэ аймгийн Түнхэл тосгонд зохион байгуулав. Хэлэлцүүлгийн үр дүнд ЗГХЭГ хот, тосгоны тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлон, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө батласан. Уг төлөвлөгөөний дагуу хуулийн заалтын хэрэгжилтийн байдлын талаар тосгон бүрээр судалгаа гаргах, хуулийн давхардсан болон зөрчилдсөн заалтыг судлаж, холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах, тосгоны асуудлыг салбарын хуулиудад тусгаж зохицуулах талаар санал боловсруулах зэрэг ажлууд хийгдэхээр болжээ.



2017.09.29-ний өдөр Сэлэнгэ аймгийн Мандал сумын Түнхэл тосгон

➤ **Монгол Улсын Үндсэн хуульд оруулах холбогдох нэмэлт өөрчлөлт, нутгийн удирдлагын эрх зүйн тулгамдсан асуудлаар бүсчилсэн, сэдэвчилсэн хэлэлцүүлэг зохион байгуулах**

Төрийн байгуулалтын байнгын хороо, ИТХ-тай хамтран 2017 оны 12 дугаар сард Сэлэнгэ, Дархан, Булган, Орхон, Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудад хэлэлцүүлэг зохион байгуулав.



2017.12.06 Дархан-Уул аймаг, 2017.12.08 Увс аймаг

Хэлэлцүүлгийг одоогийн хуулийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх, хэрэгжилтэд тулгарч байгаа асуудлыг тодорхойлох, цаашид боловсронгуй болгох саналыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгах зорилгоор баг, сум, аймгийн түвшинд нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын аль алины төлөөллийг оролцуулан саналыг сонсов. Мөн эдгээр шатны ИТХ-аас гаргасан хилийн цэс тогтоосон, албан тушаалтаныг сонгосон буюу томилсон, захиргааны хэм хэмжээний акт баталсан, татвар, төлбөрийн хувь хэмжээ тогтоосон зэрэг тогтоол шийдвэртэй танилцаж, дүн шинжилгээ хийлээ. Хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн Төрийн байгуулалтын байнгын хороонд танилцуулна.

**ҮР ДҮН 2. ИТХ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧАДАВХ САЙЖИРСАН БАЙХ**

➤ **ИТХ-ын жишиг дэг боловсруулах, батлуулах**

ЗЗНДНТУ-ын тухай хуульд “хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна”, “хуралдааныхаа дэгийг тухайн Хурал өөрөө тогтоож тогтоолоор батална” гэж заасан байдаг. Дэг нь хуралдааныг хуулийн хүрээнд саадгүй явуулах, асуудлыг шийдэх гарц бий болгох зорилготой. Гэвч хэт ерөнхий, хуулийн заалтыг хуулбарласан байдлаар дэгийг боловсруулан мөрддөгөөс хуралдаан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж чадахгүй байдалд орох тохиолдлууд практикт цөөнгүй гардаг. Түүнчлэн нийтлэг жишиг дэг байдаггүй тул ИТХ бүр хуралдааны дэгийг өөрийн үзэмжээр батлан мөрддөг. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дэг нь ил тод байдлыг хэрхэн хангаж байгаа, хэр үр нөлөөтэй болох талаар хийсэн нэгдсэн үнэлгээ дүгнэлт байдаггүй.

ИТХ-ын хуралдааны дэгийн өнөөгийн зохицуулалтын талаарх нөхцөл, байдлын үнэлгээ хийх, гарч байгаа хүндрэл бэрхшээл, хуралдааны дэгээр зохицуулах боломжгүй болсон тохиолдлуудыг судалж, ИТХ-ын дэгийн харьцуулалт хийх, сайн практикийг илрүүлэн гаргах, нийтлэг байдлаар хэрэглэж болох хуралдааны дэгд тусгах гарц, шийдлийн санал боловсруулах зорилготой зөвлөх үйлчилгээг зарлаж гүйцэтгэгчийг тендерийн хуулийн дагуу сонгон шалгаруулсан.

Тус зөвлөх үйлчилгээг “Тунгаамал төв” ТББ-ын гүйцэтгэх захирал О.Тунгалаг гүйцэтгэсэн. Зөвлөх нь жишиг дэг боловсруулахдаа:

- Дорноговь аймаг, тус аймгийн Айраг сум, нийслэл, Чингэлтэй дүүргийн ИТХ-уудад биечлэн ажиллаж,
- ИТХ-ын хуралдааны дэгийн талаар 13 аймгийн 120 гаруй сумын ИТХ-аас судалгаа авч,
- Дэгийг сайжруулах чиглэлээр ИТХ-ын төлөөлөгч, ажлын албаны ажилтан 20 гаруй хүнээс санал авч,
- 15 хуралдааны дэгийг харьцуулан судалж,
- ИТХ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, УИХ-ын тогтоолын лавлагаа бэлтгэж,
- Жишиг дэгийн төслийг бүх дүүргийн ажлын албаны ажилтнуудыг оролцуулсан уулзалтад танилцуулж, санал авчээ.

УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар Хууль эрх зүйн хэлтсийн ахлах зөвлөхүүдээс бүрдсэн Зөвлөх үйлчилгээг хүлээн авах ажлын хэсгийг байгуулсан бөнөөд Ажлын хэсэг зөвлөх үйлчилгээний явцын болон эцсийн тайлантай тухай бүр танилцаж, зөвлөмж чиглэл өгч байв. Ажлын хэсгээс *“жишиг дэгийг бүх шатны хурлын байгууллагаас батлах эрх зүйн актын загвар болох тул эрх зүйн актад тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байх, нэр томъёог хуульд заасан ойлголт, үг хэллэгтэй нийцүүлэн тодорхойлох нь зүйтэй. Энэ нь хууль зүйн ойлголтыг анхнаас нь зөв өгч, хэвшүүлэх, дадал болгох, хуралдааны соёлыг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм”* гээд дэгийн зохицуулалтыг сайжруулах чиглэлээр анхаарах асуудлын талаар зөвлөмж өгснийг Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч хүлээн авч тусгасан.

“Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны дэгийг харьцуулан судлах, жишиг дэгийн санал боловсруулах” зөвлөх үйлчилгээг ажлын даалгавар болон ажлын хэсгийн зөвлөмжид заасан ажил үүргийг тусган, сайн гүйцэтгэлтэй хийсэн байх тул Ажлын хэсэг хүлээн авах боломжтой гэж үзсэн болно.

Тус жишиг дэгийг практикт нэвтрүүлэх зорилгоор 2018 онд сургалт, зөвлөлгөөн зохион байгуулна.

➤ **Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн гарын авлага боловсруулах, ИТХ-ын үйл ажиллагаанд нэвтрүүлэх**

Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг байгууллагуудаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлсэн Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон.

Хуулийн дагуу захиргааны шийдвэр батлан гаргахад түүний хэрэгцээ шаардлагыг нотлох үр нөлөөний үнэлгээ хийж байх, цар хүрээ, эрх ашиг сонирхол нь хөндөгдөж болох бүлгийг урьдчилан тодорхойлох, хэрэгжүүлэхэд шаардагдах эдийн засаг, хүний нөөцийн тооцооллыг гаргах, шийдвэрийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, төрийн төв байгууллагад бүртгүүлэх, хэрэгжилтэд нь жил бүр хяналт үнэлгээ хийж, үр дүнг тайлагнаж байх шаардлагууд нэмэгдсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлд нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхээр заасан тул Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэлийн хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр мөн хамаарч байна. Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэснээс хойш тодорхой хугацаа өнгөрч, холбогдох байгууллагуудаас хуулийн талаар сургалт зохион байгуулагдаж байгаа ч ИТХ-д энэ талаар мэдээлэл, мэдлэг дутмаг байгаа нь судалгаанаас харагдаж байна.

ИТХ-аас захиргааны хэм хэмжээний акт гаргах ажиллагааны талаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардлагатай гарын авлага бэлтгэх, холбогдох дүрэм журмыг боловсруулах хэрэгцээ шаардлага байгаа тул төслөөс дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж зөвлөх үйлчилгээ зарлан, гүйцэтгэгчийг тендерийн хуулийн дагуу сонгон шалгаруулахад гүйцэтгэгчээр Захиргааны ерөнхий хуулийн сургагч багш, хуульч Д.Сүнжид шалгарсан. Зөвлөх үйлчилгээний хүрээнд:

- ХЗДХЯаманд бүртгэлтэй, ИТХ-аас гаргасан захиргааны хэм хэмжээний актын лавлагаа авч,
- Лавлагаанд үндэслэн хоёр аймаг, хоёр сум, нийслэл болон нэг дүүргийн ИТХ дээр очиж ажиллаж,
- Аймаг, дүүргийн ИТХ-ын ажлын албаны нарийн бичгийн дарга нар, Захиргааны ерөнхий хуулийн сургагч багш нар, Хуульчдийн холбооны гишүүд зэрэг хүмүүсээс асуулга авч,
- Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сангаас ИТХ, ИНХ-ын захиргааны хэм хэмжээний акттай холбогдох шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж,
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д зориулсан Захиргааны хэм хэмжээний акт боловсруулах гарын авлага боловсруулсан.

УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар Хууль эрх зүйн хэлтсийн ахлах зөвлөхүүдээс бүрдсэн Зөвлөх үйлчилгээг хүлээн авах ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Ажлын хэсэг зөвлөх үйлчилгээний явцын болон эцсийн тайлантай тухай бүр танилцаж, зөвлөмж чиглэл өгч байв. Ажлын хэсэг *“гарын авлагад бүх шатны ИТХ-аас баталсан Захиргааны хэм хэмжээний акт гаргаж байгаа нийтлэг зөрчил дутагдлыг засаж сайжруулах, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн анхаарах практик зөвлөмжийг санал болгоход анхаарах”*-ыг зөвлөмж болгосныг гарын авлагад тусгасан. Ажлын хэсэг зөвлөх үйлчилгээг сайн гүйцэтгэлтэй хийгдсэн байх тул хүлээн авах боломжтой гэсэн дүгнэлт гаргасан.

ИТХ-аас захиргааны хэм хэмжээний акт гаргах ажиллагааг практикт нэвтрүүлэх зорилгоор 2018 онд сургалт, зөвлөлгөөн зохион байгуулна.

- **ИТХ-ын хяналт, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх сайн туршлагыг хөхиүлэн дэмжих зорилгоор ИТХ-д тэтгэлэг олгох**

ИТХ-ын хяналт, төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэх, сайн туршлагыг хөхиүлэн дэмжих зорилгоор 2017 оны 4 дүгээр сард нийт ИТХ-уудын дунд тэтгэлэг зарласны дагуу 20 аймаг, 5 дүүрэг, 86 сумаас нийт 104 санал ирүүлэв. УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 279 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг эдгээрээс нийт 20 саналыг сонгон шалгаруулснаар тус бүр 4 сая төгрөгийн тэтгэлэг авах эрхтэй болж гэрээ байгуулан ажиллав.



№	Аймаг, дүүрэг, сумдын ИТХ	Тэтгэлгийн санал	Тэтгэлгийн чиглэл
1.	Хэнтий аймаг	Хэнтий аймгийн ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаанд зөвлөлдөх санал асуулгын арга зүйг нэвтрүүлэх	Зөвлөлдөх санал асуулга-оролцоо
2.	Дархан-Уул аймаг	ИТХ-ын хяналтын чиг үүргийг сайжруулах нь	Шилэн данс-хяналт
3.	Увс аймаг	Боловсролынхоо чанарыг мэдье, бодлогоо зөв тодорхойлъя	Төрийн үйлчилгээ- хяналт
4.	Хан-Уул дүүрэг	Иргэдийн оролцоотой ЭКО дүүрэг	Байгаль орчин-оролцоо
5.	Баянгол дүүрэг	ИТХ-ын дэргэдэх Хяналтын хорооны эрх зүйгээр хангах, хорооны гишүүдийг чадавхжуулах	ОНХС-д хяналт
6.	Налайх дүүрэг	“Хөгжлийн зөвлөл” иргэдийн оролцоог идэвхжүүлэх	Иргэдийн оролцоо
7.	Дорноговь, Айраг сум	Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлье	Байгаль орчин-хяналт
8.	Булган, Бүрэгхангай сум	Сумын бэлчээрийн менежментийг иргэдийн оролцоотой шийдвэрлэх нь	Байгаль орчин-оролцоо
9.	Хэнтий, Мөрөн сум	Байгаль орчныг хамгаалах хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг	Байгаль орчин-хяналт
10.	Говь-Алтай, Есөнбулаг сум	ИТХ-ын шийдвэрт-Иргэдийн оролцоо	Залуучууд, эмэгтэйчүүд-оролцоо
11.	Дундговь, Өлзийт сум	Олборлох салбарт эдийн засгийн үйл ажиллагаа явуулж байгаа ААН, БУЭ-ийн байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих	Байгаль орчин-хяналт
12.	Өмнөговь, Номгон сум	Сонсох ажиллагаа-Залуучуудын оролцоо	Залуучууд-оролцоо
13.	Завхан, Тэлмэн сум	Хэлэлцүүлгийн үр дүнг шийдвэрт тусгах	Шийдвэр гаргах- оролцоо
14.	Завхан, Эрдэнэхайрхан	ИТХ-ын бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	Эмэгтэйчүүд-оролцоо
15.	Сүхбаатар, Уулбаян	Иргэний танхимын үйл ажиллагааг төрийн болон ТББ-ын үйл ажиллагаатай нэгтгэж малчдыг чадавхжуулах нь	Иргэний танхим- оролцоо
16.	Баянхонгор, Бууцагаан	Орон нутагт төлөөллийн байгууллагыг бэхжүүлж хяналтыг сайжруулах нь	Иргэдийн оролцоо
17.	Увс, Зүүнговь	Иргэдийн оролцоотой хяналт	Ил тод байдал- оролцоо
18.	Хөвсгөл, Цагаан-Үүр	Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих	Байгаль орчин -хяналт
19.	Өвөрхангай, Арвайхээр	Арвайхээр сумын ИТХ ба залуучууд, иргэдийн оролцоо	Байгаль орчин- хяналт
20.	Баян-Өлгий, Буянт	ИТХ ба иргэдийн хамтын ажиллагааг дээшлүүлэх	Иргэдийн оролцоо

Тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан ИТХ-ын саналыг сайжруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах зорилгоор 05 дугаар сарын 24-ний өдөр Улаанбаатар хотноо сургалт-семинар зохион байгуулав. Сургалтын үеэр байгаль орчны хяналт сэдвээр төслийн сургагч багш, “Хил хязгааргүй алхам” ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан; төрийн үйлчилгээнд хяналт тавих сэдвээр сургагч багш, “Тунгаамал төв” ТББ-ын тэргүүн О.Тунгалаг; иргэдийн оролцоог хангах сэдвээр сургагч багш, “Энгүйнаран” ТББ-ын ажилтан Ц.Номин нар тус тус танилцуулж, холбогдох чиглэлээрх саналуудыг боловсронгуй болгох чиглэлээр хамтран ажилласан.



*ИТХ-ын үйл ажиллагааг дэмжих тэтгэлэг 2017.05.24*

ИТХ-ууд тэтгэлгийн хүрээнд зөвлөлдөх санал асуулгын арга зүйг нэвтрүүлэх, нийтийн сонгогч явуулах, цахим орчинг ашиглан залуучуудын оролцоог хангах, хэлэлцүүлгийн үр дүнг шийдвэрт тусгах зэрэг иргэдийн оролцоог хангах шинэлэг аргуудыг орон нутгийнхаа тодорхой асуудлууд дээр туршин явуулж, тодорхой хэмжээний арга зүй, туршлагатай боллоо.

Бүх ИТХ-ууд нутгийн удирдлага, ИТХ-ын чиг үүрэг, иргэдийн оролцоо, шинэ гарсан Захиргааны ерөнхий хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, Нийтийн сонгогчын тухай хуулийн ойлголт өгөх сургалтуудыг иргэд, сум орон нутгийнхаа төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудыг хамруулан явуулсан байна.

Тэтгэлгийн хүрээнд байгаль орчны хяналтын болон төрийн үйлчилгээнд ИТХ-аас хяналт тавих төслүүд амжилттай хэрэгжиж, төсөл хэрэгжүүлсэн ИТХ болон ИТХ-ын төлөөлөгчид нь хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх туршлага, арга зүй, чадавхтай болж, журмууд боловсруулан гаргаж, цаашид тогтвортой байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Жишээ нь: Увс аймгийн ИТХ нь аймгийн ИТХ-ын даргын нэрэмжит боловсролын салбар дахь гарааны мониторинг, боловсролыг дэмжих хөтөлбөрийн суурь түвшинг (өнөөгийн түвшинг) гаргасан.

Дундговь аймгийн Өлзийт сум, Хэнтий аймгийн Мөрөн сум, Дорноговь аймгийн Айраг сумын ИТХ болон ИТХ-ын төлөөлөгчид нь орон нутагт буй ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй уул уурхайн компаниудын үйл ажиллагаатай танилцаж, уул уурхайн компаниудын хуулийн дагуу байх ёстой бичиг баримтын бүрдэл, уурхай дээрээ заавал байлгах баримт бичгүүд болон тэдгээрийг дагаж мөрдөж ажиллах стандартуудын талаар мэдлэг ойлголттой болж, үнэлгээний картыг ашиглан хяналт үнэлгээ хийх чадвартай болжээ.

ИТХ-ын үйл ажиллагааг дэмжих 2017 оны тэтгэлэгт хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд 16 журам, 4 хөтөлбөрийг ИТХ-ууд боловсруулан гаргав.

Тэтгэлэг хэрэгжүүлж буй ИТХ-уудад зөвлөн туслах, чиглүүлэх, тэднийг чадавхжуулах зорилгоор хяналтын чиглэлийн төслүүдэд зөвлөх багшийг ажиллуулсны үр дүнд хяналтын чиглэлийн тэтгэлгүүд хангалттай сайн хэрэгжлээ гэж дүгнэсэн.

Аймгийн ИТХ-ууд нь тэтгэлгийн санал бичих, тэтгэлгийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх, баримтжуулах, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргах, тайлагнах хангалттай чадвар, чадавхтай байна. Гагцхүү тэд оролцоог хангах, үр нөлөө гаргах, тогтвортой байдлыг хангах, төсөл дууссаны дараа цаашид тасралтгүй үргэлжлүүлэх тал дээр анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Тэтгэлэг хэрэгжүүлэх нь төслийн саналыг бичихээс эхлээд, хамтрагч, оролцогч талууд, иргэдийн оролцоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, үйл ажиллагаа болон санхүүгийн тайлан гаргаж тайлагнах, тогтвортой байдлыг хангах зэрэг цогц, тасралтгүй үйл ажиллагаа юм. Энэ тал дээр сумын ИТХ-уудын тэтгэлэг хэрэгжүүлэх чадавх ерөнхийдөө сул байсан ч төслийн хэрэгжилтийн явцад тодорхой хэмжээний ойлголт, мэдлэг, хандлагатай болж чадавхжлаа. Харин тэтгэлэгт шалгарсан дүүргийн ИТХ-ууд тэтгэлэг төсөл хэрэгжүүлэх туршлага, чадавх, хүний нөөцтэй боловч, тэтгэлгийг хэрэгжүүлэхэд хангалттай анхаарсангүй.

➤ **ИТХ-ын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор төрийн бус байгууллагад тэтгэлэг олгох**

Нутгийн өөрөө удирдах байгууллагыг чадавхжуулахад ТББ-уудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор нутгийн удирлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын дунд тэтгэлэг зарлав. Энэ удаагийн тэтгэлгийн онцлог нь ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтын хүрээнд олгогдсон мэдлэгийг бататгах, өдөр тутмын үйл ажиллагаанд нь хэрэгжүүлж, хэвшүүлэх чиглэлээр нэг ТББ хоёр хүртэлх ИТХ-тай хамтран тэдний хэрэгцээ шаардлагад тулгуурлан санал боловсруулсан.

ТББ-ын тэтгэлэгт хамрагдахаар 14 байгууллагаас санал ирүүлснийг УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар байгуулагдсан Санал сонгон шалгаруулах хороо үнэлэн, санал нь орон нутгийн түвшинд хэрэглэх аргачлалыг бий болгох буюу боловсронгуй болгоход зорьсон, тулгамдсан асуудлыг шийдэх бодитой шинэлэг арга зүйг санал болгосон, цаашид тогтвортой хэрэгжих боломжтой байх шалгуурыг хангасан зургаан ТББ-д тус бүр 6 хүртэл сая төгрөгийн тэтгэлэг олгосон.

Хүснэгт 2

<b>НУТГИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭРХ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫГ ДЭМЖИХ ТЭТГЭЛЭГ-2017 ОН</b>		
<b>ТББ-ын нэр</b>	<b>Тэтгэлгийн санал, хүрэх үр дүн</b>	<b>Хамтран хэрэгжүүлэгч ИТХ</b>
Хил хязгааргүй алхам	ИТХ-ын ажлын хороодыг чадавхжуулах-Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах журам батлагдана Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийг хэрэгжүүлэх-2018 онд сумыг хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлийн төслийн боловсруулалт сайжирч батлагдсан байна. Захиргааны ерөнхий хуулийн сонсох ажиллагааг хэрэглэж сурах-Уул уурхайн нөхөн сэргээлтийн сөрөг нөлөөлөлд өртсөн иргэдэд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс нөхөн төлбөр олгох жишиг журам гарна. ИТХ-ын дэргэд экспертийн бүлэг байгуулагдана.	Дорноговь аймгийн Хатанбулаг сум Дорноговь аймгийн Даланжаргалан сум
Захиргааны шинэ санаачлага	Төсөв батлах явц дахь ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах-орон нутгийн төсөвт шинжилгээ хийх, тойргийн хэрэгцээг судлах, хөгжлийн зураглал гаргах арга зүйд суралцах, иргэдийн хяналтын зөвлөл байгуулах	Сэлэнгэ аймаг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум

	Нээлттэй сонсгол зохион байгуулах –аргачлал боловсруулах, үйл ажиллагааны хөтөлбөр батлах	
Нутгийн удирдлага, иргэний хяналт	Захиргааны хуулийн дагуу сонсох арга хэмжээ явуулах Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангах журам батлах	Төв аймгийн Зуунмод сум Төв аймгийн Сэргэлэн сум
Энгүйнаран	ИТХ-ын дотоод зохион байгуулалтын чадавхыг сайжруулах ИТХ-ын Нийгмийн бодлогын хорооны үйл ажиллагааг сайжруулах -үр дүнд тулгуурлан төлөвлөх жишиг аргачлал боловсруулах	Хөвсгөл аймгийн Мөрөн сум Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сум
Хөвсгөл далайн эзэд	Оролцооны гэрээ байгуулан хэрэгжүүлэх замаар ИТХ-ын чадавхыг дээшлүүлэх-үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, нөлөөллийн ажил	Төв аймгийн Заамар сум Нийслэлийн Хан-Уул дүүрэг
МНУХ	ИТХ-ын ажлын албаны ажилтнуудыг чадавхжуулах – сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах ИТХ-ын Хороодын ажиллах журмын төсөл боловсруулах ИТХ-ын үйл ажиллагааны загвар төлөвлөгөө боловсруулах	Нийслэлийн ИТХ Чингэлтэй дүүрэг

Тэтгэлэг хэрэгжүүлж буй ТББ-ууд зорилтот бүлгээс санал асуулга авах замаар хэрэгцээг тодорхойлох, хэлэлцүүлэг явуулах, сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Тухайлбал, “Захиргааны шинэ санаачлага” ТББ нь Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ИТХ төсөв хэлэлцэх үеэр хамтран ажиллаж, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоотой Иргэний хяналтын зөвлөлийг ИТХ-ын дэргэд байгуулж, сургалтад хамруулжээ. Түүнчлэн сумын ИТХ-аар орон нутгийн төсвийг хэлэлцэхийн өмнө нийтийн сонсгол зохион байгуулжээ.



*Энгүйнаран ТББ-ын тэтгэлэгийн семинар*



*МНУХ ТББ-ын тэтгэлэгийн семинар*

“Хөвсгөл далайн эзэд” ТББ Төв аймгийн Заамар сумын ИТХ-тай хамтран ажиллаж, Байгаль орчны хорооны гишүүдийг оролцуулан тус сумын байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд Төлөөлөгчийн бүрэн эрх, оролцоо ямар байх, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой аймгийн болон сумын ИТХ-аас гаргасан шийдвэрүүд хоорондоо зөрчилдөж буйг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудлыг хөндсөн хэлэлцүүлэг зохион байгуулсан байна.

➤ **[www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудасны хөтлөлт, хөгжүүлэлт**

Төслийн хэрэгжилтийн эхний үе шатанд бүтээгдсэн бүх шатны ИТХ-ын нэгдсэн портал [www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудасны байнгын тогтвортой ажиллагааг хангах, агуулгыг баяжуулах чиглэлээр энэ онд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

[www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудсыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүлээлгэн өгөв.

Төслийн Удирдах зөвлөлийн хуралдаанаар төслийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг ЗГХЭГ-тай хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу ИТХ-д мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийнхээ хүрээнд ЗГХЭГ нь khural.mn цахим хуудсыг цаашид хариуцан ажиллахаар болсон. ЗГХЭГ-ын Орон нутгийн удирдлага зохицуулалтын газар, Мэдээллийн технологийн хэлтэс 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авч, системийн ажиллагааг бүрэн хариуцан ажиллаж байна. ЗГХЭГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн холбогдох ажилтан 360 гаруй дэд хуудасны админуудад өдөр тутам тусламж, заавар өгч, хэрхэн сайжруулж, шинэчлэх талаар санал санаачилга гарган ажиллаж байгаа нь тус цахим хуудсыг цаашид тогтвортой байлгахад чухал хувь нэмэр болж байна.

### Дүүргийн админы сургалт

Нийслэлийн дүүргүүдийн дэд цахим хуудсыг хөтлөгч хөгжүүлэгч админы сургалтыг 03 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулав. Сургалтад нийслэлийн 9 дүүрэг тус бүрээс хоёр, аймгийн сургалтад хамрагдаж амжаагүй Сэлэнгэ аймгийн админууд болон ЗГХЭГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн хоёр ажилтан, нийт 22 админ хамрагдлаа.

Хүснэгт 3

Нийт оролцогч	эр		эм		Өмнө нь сургалтад хамрагдаж байсан	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
22	9	40.9	13	59.1	4	18.2

Сургалтын ерөнхий агуулгыг цахим хуудсыг бүтээгч “Идеа девелопмент” компанийн мэргэжилтнүүд хүргэж, цахим хуудасны мэдээ бэлтгэх арга зүйн талаар Глоб Интернэйшнл Төв ТББ-ын багш Х.Наранцэцэг, цахим хуудасны стандарт шаардлагыг мөрдөн ажиллах талаар УИХ-ын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн шинжээч Г.Хэрлэн нар танилцуулав.



Нийслэлийн дүүргүүдийн админы сургалт 2017.03.24-25

Цахим хуудасны хөтлөгч, хөгжүүлэгчийн сургалтыг зохион байгуулснаар админууд мэргэжлийн сургалт, заавар зөвлөгөө авахын зэрэгцээ бусад дүүргийн админаас харилцан сайн туршлага солилцсон нь ач холбогдолтой байв. Сургалтын үеэр админууд дэд цахим хуудсыг хөгжүүлэх, сумдын админуудад сургалт зохион байгуулах зэрэг чиглэлээр ойрын хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргасан.

### Сургалтын хяналт-үнэлгээ:

Админы сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, сургалтын үеэр олж авсан мэдлэг чадвар, суралцсан сайн туршлагыг баримтжуулах, ажил үүргийн

хуваарьт админы чиг үүрэг хэрхэн тусгагдсан болон цахим хуудсыг хөтлөх хөгжүүлэх стандартыг хэрхэн мөрдөн ажиллаж байгаа, тулгарч буй бэрхшээлийг тогтоох зорилгоор хяналт үнэлгээний санал асуулга боловсруулан оролцогчдоос авсан.

*Сургалтын хэрэгцээ, шаардлага:* Энэ удаагийн админы сургалт эрэлт хэрэгцээтэй, сургалтын агуулга сайн гэж оролцогчид 100 хувь үнэлсэн байна. Оролцогчид дэд цахим хуудсыг хэрхэн удирдах, мэдээ нийтлэл, бэлтгэх, нийтлэх, стандарт шаардлагыг хэрхэн баримтлах зэргийг суралцахын зэрэгцээ бусад дүүргийн сайн туршлагаас суралцсан гэжээ. Тухайлбал, дэд цахим хуудасны бүтцийг оновчтой үүсгэх, хандалтыг нэмэгдүүлэх, иргэдэд сурталчлан таниулах талаар шинэ санааг сургагч багш нараас болон бусдаасаа суралцжээ.

*Дэд цахим хуудсыг сурталчлах:* Дүүргийн админуудын 52.6% нь дэд цахим хуудасны мэдээллийг фейсбүүк групп, хуудаст тогтмол оруулдаг бөгөөд мөн дараах байдлаар сурталчилдаг гэжээ:

- Иргэний танхим
- нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр
- дүүргийн зар мэдээгээр
- арга хэмжээнүүдийн слайд, шторк зэргийн аль нэг хэсэгт байнга байршуулдаг
- дүүргийн цахим хуудастай холбодог.

*Цахим хуудас хөгжүүлэгч админы чиг үүрэг:* Khural.mn цахим хуудасны хөтлөгч, хөгжүүлэгчийн чиг үүрэг ажил үүргийн хуваарьт нь хэрхэн тусгагдсан талаар тодруулахад:


- үр дүнгийн гэрээнд тусгагдсан гэж 5 /26.3%/
- ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан гэж 5 /26.3%/
- тусгагдаагүй гэж 8 /42.1/ хүн тус тус хариулсан байна.

Аймаг, сумдын ИТХ нь khural.mn цахим хуудсыг үндсэн цахим хуудсаа болгон идэвхтэй хөтлөж хөгжүүлдэг бол нийслэл, дүүргийн ИТХ-ууд [www.bgd.mn](http://www.bgd.mn); [www.sbd.gov.mn](http://www.sbd.gov.mn); <http://bzd.ub.gov.mn> гэх мэт өөр цахим хуудсыг давхар хөгжүүлдэг байна. Энэ нь дүүргүүдийн дэд цахим хуудасны хөгжүүлэлтэд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг тул энэ асуудлыг нэг мөр цэгцэлж, ИТХ-уудын нэгдсэн цахим хуудас болохынх нь хувьд khural.mn-ийг цаашид үндсэн хуудас болгон ашиглаж байх саналыг админууд гаргаж байв.

#### *Дэд цахим хуудсыг хөгжүүлэх уралдаан:*

Дэд цахим хуудасны тогтвортой байдлыг хангах, хөтлөлт хөгжүүлэлтийг сайжруулах, стандартыг мөрдөж хэвшүүлэх, ИТХ-ын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 11 дүгээр сард аймаг, сум, дүүргийн админы дунд уралдаан зарлав.

Цахим орчны хэрэглээний нөхцөл боломж, бэлтгэгдсэн ажилтаны нөөц зэрэг харилцан адилгүй байдлаас шалтгаалан ИТХ-ын дэд цахим хуудасны байнгын ажиллагаа ялгаатай хөгждөгийг харгалзан, шалгаруулалтыг аймаг, сум, дүүргийн түвшинд явуулсан нь энэ удаагийн уралдааны онцлог байв.



УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг уралдаанд оролцохоор тогтоосон хугацаанд ирүүлсэн тайлангуудтай танилцан, эдгээр цахим хуудас бүрт нэг бүрчлэн дүн шинжилгээ хийсэн. Ингэхдээ дэд цахим хуудасны тогтвортой хөгжүүлэлт; ИТХ-ын үйл ажиллагаа, шийдвэр нь иргэдэд нээлттэй, ил тод эсэх; админы идэвх санаачлагатай ажиллаж буй байдал зэрэг олон үзүүлэлтийг шалгуур болгож, аймаг, сум, дүүргийн нийт 42 дэд цахим хуудсыг шалгаруулан урамшууллаа. Уралдааны үр дүнд:

- ИТХ-ын дарга, тэргүүлэгчид, төлөөлөгчдийн товч танилцуулга
- ИТХ-ын танилцуулга, үүний дотор хурлын хороод, иргэний танхим, хурлын дэргэдэх байгууллагуудын мэдээлэл
- Ажлын албаны танилцуулга
- Иргэдийн Нийтийн Хурлын мэдээлэл
- ИТХ-ын тогтоол, шийдвэр
- Үйл явдлын мэдээ зэрэг дэд цахим хуудасны нийтлэлийн тоо эрс нэмэгдэж, мэдээллийн агуулга сайжрахийн зэрэгцээ ИТХ-ын үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэхэд нөлөөлөв.

### **ҮР ДҮН 3. ОРОН НУТГИЙН СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙНГЫН МЕХАНИЗМТАЙ БОЛОХ**

#### **➤ Бүх шатны ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан суурь сургалт**

2016 оны 06 дугаар сард аймаг, нийслэлийн; 10 дугаар сард сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгууль явагдсан бөгөөд сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан ИТХ-ын төлөөлөгчдийн 60 гаруй хувь нь анх удаагаа сонгогдсон байна. Иймд шинээр сонгогдсон төлөөлөгчдөд зориулж суурь сургалтыг цаг алдалгүй зохион байгуулах хэрэгцээ шаардлага гарч, 2016 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдөд болон 21 аймгийн ИТХ, 9 аймгийн сумдын ИТХ-ын төлөөлөгчдийг хамруулан сургалт зохион байгуулсан.



2017 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд бусад 12 аймгийн сумдын болон нийслэлийн 9 дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт зохион байгуулагдлаа. Аймаг, дүүргийн ИТХ-ын ажлын албад сургалтын зохион байгуулалтыг хариуцан ажилласан бөгөөд төслийн зүгээс холбогдох удирдамж, чиглэлээр хангав. Үүнд:

- Төлөөлөгчдийн сургалтад ажиллах сургагч багш нарын ажлын удирдамж
- Төлөөлөгчдийн сургалт зохион байгуулах аймгийн ИТХ-ын ажлын албаны ажлын удирдамж
- Сургалтын хяналт-үнэлгээний ажлын удирдамж
- Сургалтын санхүүжилтийг зарцуулах ажлын удирдамж. Ингэснээр сургалтыг үндэсний хэмжээнд стандартын дагуу зохион байгуулах боломж бүрдсэн.

Хүснэгт 4

№	Аймаг	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт				Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн сургалт			
		Огноо	Нийт төлөө лөгч	Сургалтад хамрагдсан		Огноо	Нийт төлөөл өгч	Сургалтад хамрагдсан	
				тоо	хувь			тоо	хувь
1	Архангай	2016 оны 11 сар	39	33	84.6	2017 оны 1 сар	433	409	93.6
2	Баян-Өлгий	2016 оны 12 сар	39	36	92.3	2017 оны 1 сар	329	293	89.4
3	Баянхонгор	2016 оны 11 сар	41	41	100	2016 оны 12 сар	418	418	100
4	Булган	2016 оны 12 сар	33	30	90.9	2017 оны 2 сар	340	280	83.1
5	Говь-Алтай	2016 оны 12 сар	40	35	87.5	2017 оны 4 сар	363	303	83.9
6	Говьсүмбэр	2016 оны 11 сар	16	11	68.8	2016 оны 11 сар	67	59	84.3
7	Дархан-Уул	2016 оны 11 сар	33	31	93.9	2016 оны 12 сар	106	101	95.0
8	Дорноговь	2016 оны 12 сар	31	28	90.3	2017 оны 2 сар	272	259	94.7
9	Дорнод	2016 оны 11 сар	35	35	100	2016 оны 11 сар	274	256	94.2
10	Дундговь	2016 оны 11 сар	35	35	100	2017 оны 2 сар	295	295	100
11	Завхан	2016 оны 11 сар	40	40	100	2016 оны 11 сар	442	416	94.6
12	Орхон	2016 оны 12 сар	33	23	69.7	2016 оны 12 сар	52	41	75.3
13	Өвөрхангай	2016 оны 11 сар	41	31	75.6	2017 оны 1 сар	447	416	91.6
14	Өмнөговь	2016 оны 11 сар	33	12	36.4	2016 оны 11 сар	305	252	78.1
15	Сүхбаатар	2016 оны 12 сар	33	28	84.8	2017 оны 3 сар	271	257	93.8
16	Сэлэнгэ	2016 оны 11 сар	37	30	81.1	2017 оны 2 сар	387	323	83.3
17	Төв	2016 оны 10 сар	41	34	82.9	2017 оны 3 сар	529	432	81.8
18	Увс	2016 оны 11 сар	41	41	100.0	2016 оны 11 сар	403	372	93.0



19	Ховд	2016 оны 11 сар	41	24	58.5	2016 оны 11 сар	371	356	92.2
20	Хөвсгөл	2016 оны 12 сар	41	41	100.0	2017 оны 1 сар	517	517	100
21	Хэнтий	2016 оны 11 сар	39	31	79.5	2017 оны 2 сар	380	365	94.5
	<b>Нийт</b>		<b>762</b>	<b>650</b>	<b>85.3</b>		<b>7001</b>	<b>6420</b>	<b>92</b>

Нийслэлийн дүүргүүдийн ИТХ-ын ажлын алба мөн дүүргийнхээ сургалтыг хариуцан зохион байгуулсан нь өмнөх удаагийн сургалттай харьцуулахад ирц сайн байхад нөлөөлсөн.

Хүснэгт 5

№	Дүүрэг	Огноо	Нийт төлөөлөгч	Сургалтад хамрагдсан	
				тоо	хувь
	Нийслэлийн ИТХ	2016.09.08.22	45	35	77.8
1	Чингэлтэй	2017.02.02-03	35	30	85.7
2	Багануур	2017.03.11-12	25	24	96.0
3	Багахангай	2017.03.10-11	17	15	88.2
4	Налайх	2017.03.10-11	21	17	81.0
5	Хан-Уул	2017.04.14-15	35	22	62.9
6	Сүхбаатар	2017.04.06-07	35	35	100
7	Сонгинохайрхан	2017.04.06-07	41	31	75.6
8	Баянгол	2017.04.20-21	41	27	65.9
9	Баянзүрх	2017.04.21-22	41	36	87.8
	<b>Нийт</b>		<b>291</b>	<b>272</b>	<b>86.1</b>

Дүүргийн сургалтын нэг онцлог нь 1-2 сэдвийн хичээлийг Удирдлагын академийн багш нар хөтлөн явуулав.



Чингэлтэй дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалт  
2017.02.02



Сүхбаатар дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалт  
2017.04.07




Багануур дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалт  
2017.03.12

Орон нутгийн 2016 оны сонгуулийн үр дүнд сонгогдон бүрэн эрх нь хэрэгжиж буй бүх шатны ИТХ-ын 8099 төлөөлөгчийн 7377 нь буюу 91.1 хувь үндэсний суурь сургалтад хамрагджээ.

Хүснэгт 6

ИТХ	Нийт төлөөлөгчийн тоо	Сургалтад хамрагдсан			
		тоо	хувь	эрэгтэй	эмэгтэй
Аймаг	762	650	85.3	541	109
Сум	7001	6420	91.7	4668	1752
Нийслэл	45	35	77.8	28	7
Дүүрэг	291	272	86.1	197	75
<b>ДҮН</b>	<b>8099</b>	<b>7377</b>	<b>91.1</b>	<b>5434</b>	<b>1943</b>

Төслийн эхний шатанд буюу ИТХ-ын төлөөлөгчдийн анхдугаар суурь сургалтад нийт сонгогдсон төлөөлөгчийн 88.6 хувь, үүний дотор нийслэлийн дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн 59 хувь нь хамрагдаж байсан<sup>1</sup> бол энэ удаагийн сургалтын ирц оролцоо сайжирсан нь аймаг, дүүргийн ИТХ-ын ажлын алба сайн ажилласан, сонгуулийн дараа зохион байгуулснаар төлөөлөгчдөд шаардлагатай цаг үед хэрэгцээт мэдээллийг өгсөн сургалт болсон гэж үзэж болно.



**Сургалтын хяналт-үнэлгээ:**

Аймаг, дүүргийн ИТХ-ын ажлын албад сургалтын зохион байгуулалт, санхүүгийн стандартыг хэрхэн ханган ажиллаж байгаад болон сургагч багш нарын заах арга зүй, төлөөлөгчдийн ирц, идэвх оролцоо, сургалтын явцад хяналт үнэлгээ хийж ажилласан.

УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон төслийн ажилтнууд Өвөрхангай, Дархан-Уул, Баян-Өлгий, Говь-Алтай, Дундговь, Төв зэрэг аймгууд болон нийслэл хотод хоёр өдөр вакумжин зохион байгуулагдсан дүүргүүдийн сургалтад ажиллалаа. Мөн төлөөлөгчдөөс сургалтын өмнөх болон сэдвийн үнэлгээний санал асуулга авав.

Санал асуулгад оролцогчдын дийлэнх олонх нь сургалтын сэдэв, агуулгыг ач холбогдолтой, зөв, оновчтой, зохион байгуулалт сайн, сургагч багш нарыг туршлагатай, чадварлаг зэргээр үнэлсэн байна. Харин цаашид сайжруулах, анхаарах асуудлын талаар дараах саналуудыг гаргажээ. Үүнд:

- Хуулийн хэллэгийг энгийн, ойлгомжтой болгох
- Сургалтын агуулгыг орон нутгийн тулгамдсан асуудлын талаарх жишээ, кейсээр баяжуулах
- Өмнө сонгогдсон болон анх удаа сонгогдсон төлөөлөгчдийг ялгаатай агуулгаар сургах
- Сургалтын давтамжийг ойртуулах
- Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын дарга, тэргүүлэгчид, ИТХ-ын ажлын албаны ажилтнуудыг сургалтад хамруулах

<sup>1</sup> “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн 2014 оны тайлан

- Гадаад орны болон бусад аймаг, сум, дүүргийн туршлагаас судлах, харилцан суралцах
- Орон нутгийн сургагч багш нарын тоог нэмэгдүүлэх
- Дүүргүүдээс сургагч багш бэлтгэх
- Гарын авлагыг казак хэл дээр хэвлэх зэрэг болно.

Санал асуулгын дүн, ИТХ-ын төлөөлөгчид, ажлын албаны ажилтнуудтай биечлэн болон утсаар хийсэн ярилцлага, сургалтын явцад хяналт-үнэлгээ хийсэн ажилтнуудын тайлан зэргийг нэгтгэн дүгнэхэд:

- Сургалтын агуулгыг төлөөлөгчдийн туршлага буюу сонгогдсон байдлыг харгалзан харилцан адилгүй байдлаар боловсруулах санал их гарч байв. Анх удаа сонгогдсон, үүний дотор сумын ИТХ-ын төлөөлөгчдийн олонх нь төлөөлөгчийн болон ИТХ-ын чиг үүрэг, эрх хэмжээний талаар ойлголт муутай байдаг бөгөөд сургалтаас энэ талаарх анхан шатны, суурь мэдлэгийг олж авдаг байна. Сургалтад хамрагдсан нийт төлөөлөгчид сургалтын үр дүнг өндрөөр үнэлдэг хэдий ч зарим туршлагатай, 3-4 удаа сонгогдсон төлөөлөгчид өмнө үзсэн агуулгаараа л дахин суралцлаа гэж байв.
- Сургалтын явцад төлөөлөгчдийг бүлгээр ажилуулахдаа тухайн бүлэгт сум бүрийн төлөөллийг оруулдаг нь тэдэнд бие биенийхээ туршлагаас хуваалцах боломжийг олгодог. Ингэснээр тэд зөвхөн сургалтын агуулга, сургагч багшаас төдийгүй бусад хурлын сайн туршлагаас давхар суралцдаг байна.
- Үндэсний суурь сургалт дөрвөн үндсэн сэдвийг хамарсан. Харин төлөөлөгчид бусад олон чиглэлээр, тодорхой хугацааны давтамжтайгаар сургалт авах хүсэлтээ илэрхийлж байв. Тухайлбал, шинээр батлагдсан Захиргааны ерөнхий хууль, Нийтийн сонсголын хууль зэрэг хууль болон бусад хууль тогтоомж дахь ИТХ-ын чиг үүрэг, эрх хэмжээг зохицуулсан хуулийн зүйл заалт, зохицуулалтын талаар мэдээлэл авч, хуулийг хэрхэн хэрэглэх, мөрдөн ажиллах талаар мэдлэг хэрэгцээтэй байна гэв.
- Баян-Өлгий аймагт хяналт үнэлгээгээр ажиллах явцад тус аймгийн сумдын зарим төлөөлөгчид монгол хэлний мэдлэг тааруугаас хэлмэрчлүүлэн ойлгож байв. Тэд сургалтын гарын авлагыг тодорхой тоогоор казак хэлээр хэвлэх хүсэлт тавьж байлаа.

### **Сургалтын үр дүнгээс:**

Сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн 43 хувь, тэргүүлэгчдийн 35 хувь, дарга нарын 20 гаруй хувь нь дунд боловсролтой. Түүнчлэн аймаг, нийслэл, дүүргийн төлөөлөгчдийн 60 гаруй хувь, сумдын төлөөлөгчдийн 56 хувь нь ИТХ-д анх удаа сонгогджээ. Эдгээр төлөөлөгчид ИТХ-ын болон төлөөлөгчийн эрх, хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэх ажил үүргийн талаар ойлголт тааруу байдаг бөгөөд энэ талаарх мэдлэг, мэдээллийг төслийн суурь сургалт олгож буйгаараа чухал ач холбогдолтой юм.

Манай сумын ИТХ-аас гаргасан нэг тогтоолыг Засаг дарга хүчингүй болгох шийдвэр гаргасан байсан. Сургалтаас “хурлаас гаргасан тогтоол, шийдвэрийг тухайн Хурал өөрөө өөрчлөх буюу хүчингүй болгох” эрх зүйн зохицуулалтыг сонсож мэдсэнээр төлөөлөгчид тогтоолоо хэвээр үлдээсэн.

Түүнчлэн манай төлөөлөгчид сургалтын дараа хуралдааны дэгээ баталсан. Ингэснээр тэдний ирц, идэвх эрс сайжирсан.

*Баян-Өлгий аймгийн Буянт сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга*

Орон нутгийн төсөв төлөвлөлтийн үе шат, явц, төсөв бүрдүүлэлт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэн гүйцэтгэх ажилд тавих хяналтын чиглэлээр хэрэгжүүлж буй ИТХ-ын үйл ажиллагаанд ахиц гарч байна.

Манай аймаг, сумдын ИТХ-ын бодлогын хороод нь Төлөөлөгчийн бүрэн эрхийн хэмжээнд төсөв, санхүү, өмч хөрөнгө болон ард иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал хүсэлтийн мөрөөр хяналт шалгалт хийх удирдамж боловсруулан ажиллаж болох талаар уг сургалтаас мэдэж авсны дагуу хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Тухайлбал, ИТХ-ын зарим хороод хамтран ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажилд 2017.03.27-ны өдөр хяналт шалгалт явуулсны дүнд зарим зөрчил дутагдлыг илрүүлэн, тогтоол гаргаж “цаашид ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэн хийж гүйцэтгэх ажлын явцад тавих хяналтыг сайжруулан, ОНХС-ийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулахад анхаарч, төрийн албан хаагчдын ур чадвар, хариуцлагыг өндөржүүлж, албаны баримт бичгийн стандартыг мөрдөж, эмх цэгцийг сайжруулан, судалгаанд үндэслэн, төлөвлөлттэй, хурдтай ажиллах арга барилд мэргэшүүлэх”-ийг сумын засаг дарга А-д даалгасан.

Түүнчлэн Сумын төсвийн орлого зарлагыг нилээд сайн тооцож сурч байгаа бөгөөд орон нутагт зардал багасгах, орлого нэмэгдүүлэх боломжуудыг судласанаар төсвийн тодотголоор хэд хэдэн асуудлууд шийдвэрлэж чадсан.

*Булган аймгийн ИТХ-аас ирүүлсэн сайн жишээ*

Орон нутгийн ИТХ-ын бүрэлдэхүүнд тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалтнууд олон байдаг байна. Эдгээр төлөөлөгчдөд сургалтын агуулга ойр, сургалтаас олж авсан мэдлэгийг зөвхөн төлөөлөгчийн хувиар төдийгүй төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагаандаа ашиглаж болох юм.

➤ **Багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт зориулсан суурь сургалт:**

*Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах:*

Үндэсний сургагч багш нарын сургалт /2017.03.30/-ын үеэр багийн ИНХ-ын дарга нарыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр, агуулгыг сургагч багш нарын нөөц бололцоонд тулгуурлан боловсруулах санал гарсан. Үүний дагуу агуулга боловсруулах ажлын хэсэгт ажиллах сонирхолтой сургагч багш нарыг хөтөлбөрт тусгах саналаа ирүүлэхийг урьж, нээлттэй зарласан бөгөөд санал ирүүлсэн сургагч багш нар МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш Д.Ганзоригоор ахлуулан ажиллаж, сургалтын хөтөлбөрийг боловсруулав.


Тус сургалтын хөтөлбөр нь ИНХ-ын эрх зүйн үндэс, суурь ойлголт; хуралдаан; тэргүүлэгчид; багийн өөрөө удирдах ёс ба иргэдийн оролцоо; шийдвэр, түүний хэрэгжилтэд хяналт тавих нь; багийн хэмжээнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх нь гэсэн зургаан сэдэв бүхий нийт 18 цагийн агуулга бүхий сургалт юм.

Сургалтын агуулга боловсруулах ажлын хэсэг нь сургагч багш нарт болон ИНХ-ын дарга нарт зориулсан хоёр төрлийн гарын авлагыг боловсруулав. ИНХ-ын дарга нарт зориулсан гарын авлагад багийн ИНХ-тай холбоотой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн эмхэтгэл, архив бичиг хэргийн стандарт болон Хурлын үйл ажиллагаанд нийтлэг хэрэглэгддэг баримт бичгийн жишиг загвар, бэлчээр ашиглалтын гэрээний загвар зэрэг сайн туршлага, сургамжуудыг багтаалаа.

*Багийн ИНХ-ын дарга нарын сургалт зохион байгуулах:*

Багийн иргэдийн Нийтийн хурлын дарга нарыг чадавхжуулах сургалтыг 10-11 дүгээр сард бүх аймагт зохион байгуулав. Сургалтын бэлтгэл ажлын хүрээнд багийн ИНХ-ын талаар судалгааг анх удаа авч нэгтгэн, суурь мэдээлэлтэй болов. Монгол Улсын хэмжээнд нийт 1612 багийн ИНХ-ын дарга ажиллаж байна.

### Багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарын судалгаа 2017 он



Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын сургагч багш нарыг бэлтгэх сургалтын үеэр ИНХ-ын дарга нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байдаг сумдын ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарыг мөн сургалтад хамруулах хүсэлтийг аймгуудаас гаргасныг хүлээн авч, энэ удаагийн сургалтад нийт 1562 багийн ИНХ-ын дарга, 307 сумдын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга хамрагдсан.

Хүснэгт 7

	Аймаг	сургалтын огноо	нийт багийн ИНХ-ын дарга	сургалтад хамрагдсан БИНХ дарга	хувь	сумдын ИТХ-ын нбд	сургалтад хамрагдсан нбд	хувь
1	Архангай	2017.11.16-17	101	95	94.1	19	19	100.0
2	Баян-Өлгий	2017.11.08-09	89	79	88.8	13	13	100.0
3	Баянхонгор	2017.11.01-02	104	104	100.0	20	20	100.0
4	Булган	2017.10.30-31	75	67	89.3	16	15	93.8
5	Говь-Алтай	2017.11.03-04	87	87	100.0	18	18	100.0
6	Говьсүмбэр	2017.10.26-27	10	10	100.0	3	3	100.0
7	Дархан-Уул	2017.11.02-03	26	26	100.0	4	4	100.0
8	Дорноговь	2017.10.26-27	64	64	100.0	14	14	100.0
9	Дорнод	2017.10.30-31	66	66	100.0	14	14	100.0
10	Дундговь	2017.11.01-02	66	66	100.0	15	15	100.0
11	Завхан	2017.11.13-14	115	115	100.0	24	24	100.0
12	Орхон	2017.11.09-10	24	23	95.8	2	2	100.0
13	Өвөрхангай	2017.10.30-31	109	108	99.1	19	19	100.0
14	Өмнөговь	2017.11.14-15	58	57	98.3	15	12	80.0

15	Сүхбаатар	2017.11.06-07	67	64	95.5	13	13	100.0
16	Сэлэнгэ	2017.11.02-03	56	56	100.0	17	17	100.0
17	Төв	2017.11.14-17	97	87	89.7	27	27	100.0
18	Увс	2017.11.05-06	93	90	96.8	19	0	0.0
19	Ховд	2017.11.08-09	91	89	97.8	17	17	100.0
20	Хөвсгөл	2017.10.23-26	126	126	100.0	23	23	100.0
21	Хэнтий	2017.11.09-10	88	84	95.5	18	18	100.0
	<b>ДҮН</b>		<b>1612</b>	<b>1563</b>	<b>97.0</b>	<b>330</b>	<b>307</b>	<b>93.0</b>

Сургалтад нийт багийн ИНХ-ын дарга нарын 97 хувь, сумдын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга нарын 93 хувь нь оролцжээ.

Хүснэгт 8

	Нийт	Сургалтад хамрагдсан:	Хувь	Сургалтад оролцогсод/хүйсээр			
				эрэгтэй	хувь	эмэгтэй	хувь
Багийн ИНХ-ын дарга	1612	1563	97%	1051	67.2%	512	32.8%
Сумдын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга	330	307	93%	124	40.4%	183	59.6%
<b>Нийт</b>		<b>1870</b>		<b>1175</b>	<b>62.8%</b>	<b>695</b>	<b>37.2%</b>

Багийн ИНХ-ын дарга нарын сургалт нь ИНХ-ын эрх зүйн үндэс, суурь ойлголт; хуралдаан; тэргүүлэгчид; багийн өөрөө удирдах ёс ба иргэдийн оролцоо; шийдвэр, түүний хэрэгжилтэд хяналт тавих нь; багийн хэмжээнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх нь гэсэн зургаан сэдэв бүхий нийт 18 цагийн агуулгатай хоёр өдрийн сургалт юм. Сургалтын агуулгыг төслийн хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш нар оролцогчдод хүргэсэн.



Архангай аймаг, 2017.11.16-17



Баян-Өлгий аймаг, 2017.11.08-09



Баянхонгор аймаг, 2017.11.01-02

Мөн ШХА-ын төслүүдийн хамтын ажиллагааны хүрээнд “Ногоон алт” төслөөс бэлчээрийн менежментийн талаар аймгийн Бэлчээр ашиглагчдын холбооны сургагч багш нар танилцуулга хийж, орон нутагтаа бэлчээр ашиглалтыг сайжруулах асуудлыг шийдвэрлэхэд хэрхэн хамтран ажиллах талаар ярилцаж, санал солилцсон нь цаашдын хамтын ажиллагааны суурь болов.

### Сургалтын хяналт-үнэлгээ

Сургалтын зохион байгуулалтыг аймгийн ИТХ-ын ажлын алба хариуцан, Төслийн нэгжтэй байгуулсан гэрээний дагуу зохион байгуулалт, санхүү, хяналт-үнэлгээний удирдамжийг баримтлан ажилласан. Сургалтын өмнөх болон дараах санал асуулгыг оролцогчдоос авсан. Сургалтын өмнөх санал асуулгыг одоогийн


багийн ИНХ-ын хуралдаан хэрхэн явагддаг, иргэдийн оролцоо ямар байдаг болон тэдэнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох зорилготой байв.

Санал асуулгад сургалтад оролцогчдын 85 хувь нь хамрагдсан байна.


Хүснэгт 9

Санал асуулгад оролцогсод	хүйс		боловсрол		
	эр	эм	дээд	дунд	бага
	63.3%	36.7%	42.3%	51.5%	2.9%


Санал асуулгын дүнгээс харахад ихэнх багийн ИНХ нь жилд 3-4 удаа хуралддаг бөгөөд дунджаар 50-70 хүний ирцтэй байдаг байна.



Хуулиар тухайн Хурал хуралдааныхаа дэгийг өөрөө тогтоохоор заасан байдаг. Харин нийт багийн ИНХ-ын 16.9 хувь нь дэгээ батлаагүйн зэрэгцээ батлан мөрдөж буй дэг нь хуралдаантай холбоотой аливаа харилцааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэхийг нарийвчлан судлах, сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай нь бусад судалгаанаас харагддаг. Мөн багийн Засаг дарга ИНХ-ын шийдвэрийг хэрэгжүүлж чаддаггүй гэж судалгаанд оролцогчдын 17.3 хувь нь хариулжээ.



Багийн ИНХ ихэнх тохиолдолд Тэргүүлэгчдийн саналаар болон иргэдийн хүсэлтээр хэлэлцэх асуудлаа тогтдог бол зарим Хурал дээд шатны байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу тогтоодог гэсэн нь анхаарал татаж байгаа юм.



Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нь багийн ИНХ-ын даргад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, мэдээллээр ханган ажилладаг байна.

Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалт үндэсний хэмжээнд анх удаа зохион байгуулагдсан бөгөөд оролцогчид сургалтаас төдийгүй бие биенийхээ туршлагаас их зүйл суралцаж байгаагаа хэлж байсан.

Архангай аймагт сургалтын үеэр ИНХ-уудын ажлын туршлага, баримт бичиг, тогтоол шийдвэр, ажлын төлөвлөгөө зэргээр үзэсгэлэн самбар гаргаж харилцан сурталчилгаа хийсэн нь сайн жишээ болсон.

*Сургагч багш А.Гэлэжамцийн тайлангаас*

Цаашид багийн ИНХ-ын дарга нарыг сэдэлжүүлж, сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвараа амьдралд хэрэгжүүлэхэд нь хэрхэн дэмжиж болох талаар аймгийн ИТХ-ын ажлын алба болон сургагч багш нар дараах саналыг гаргав:

- ИНХ-ын тэргүүлэгчдийг сургалтад хамруулах
- ИНХ-ын дарга нарын туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж байх
- Аймгийн ИТХ-ын Ажлын албаны ажилтнуудыг сургалт зохион байгуулах арга зүйд сургах
- Багийн түвшинд байнга тулгамдаж байдаг нийтлэг асуудлыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэхэд мөрдөж ажиллах журмын төслийг боловсруулж, мөрдөж хэвшүүлэх
- ИНХ-уудын сайн туршлагыг цуглуулж баримтжуулах, сургалтад ашиглах
- Багийн хөгжлийн тулгамдсан асуудал, цаашдын зорилтын асуудлаар улсын хэмжээний нэгдсэн зөвлөлгөөн зохион байгуулах.

Нэг ширээнд сууж байгаа хүмүүсээс болон бусад хүмүүсийн ярианаас чухал санаануудыг авч, сайн туршлагуудыг мэдэж авлаа. Хуулийн хүрээнд зөв менежментээр хурлын үйл ажиллагааг амьд болгох хэрэгтэй юм байна гэсэн санааг авлаа. Хуулийн хүрээнд гэж тодотгож байгаагийн учир нь сүүлийн үед олон хууль гарсан учраас бид хуулийг судалж, зөв хэрэглэж сурах шаардлага байна. Эдгээр хуулиуд гараагүй, 2000 оны эхээр 97, 98 онуудад хурлын дарга хийж байхад хуулийн заалт байхгүй, БИНХ-аар хэлэлцээд, ТОГТООХ нь гээд явдаг байсан. Одоо бол тогтоол шийдвэр гаргахын тулд БИНХ-ын дарга нар бид нэлээн хууль эргүүлж, заалтуудыг судлах, мэдэх хэрэгтэй болж байгааг ойлголоо.

*Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Агарын багийн ИНХ-ын дарга*



Аймгийн ИТХ-ын ажлын албад сургалтын зохион байгуулалтын стандартыг хэрхэн ханган ажиллаж байгаад болон сургагч багш нарын заах арга зүй, оролцогчдын ирц, идэвх оролцоонд хяналт тавьж, үнэлэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ШХА болон төслийн ажилтнууд 10 аймагт ажилласан. Томилолтоор ажилласан ажилтнууд хяналт үнэлгээний тайланд дараах асуудлыг анхаарахаар тусгажээ:

- Ажлын албад сургалтыг сайн зохион байгуулсан. Өмнө төслийн хүрээнд хийгдсэн сургалтуудад ажиллаж байсан тул туршлагажиж, ажлын албаны зохион байгуулалтын чадавх нь сайжирсан гэж болно.
- Зарим сургагч багш нарын хувьд сэдвийн агуулга, слайдыг өөрийн болгож бэлдээгүй, хувийн бэлтгэлээ тааруу хангасан зүйл ажиглагдаж байв.
- Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалт анх удаа явагдаж байгаа нь тэдэнд бие биетэйгээ танилцаж, туршлага солилцох, цаашид хамтран ажиллахад томоохон нөлөө үзүүлж, урамшуулж, сэдэлжүүлсэн арга хэмжээ болж байгаа нь харагдаж байв.
- Хууль, эрх зүйн зохицуулалттай холбоотойгоор ИНХ-ын дарга нар орон тооны бус, багийн Засаг даргын цалингийн 30 хувьтай тэнцэх урамшуулал авдаг, албан өрөө тасалгаа байдаггүйгээс тамга, тэмдгийг гэртээ хадгалдаг зэрэг хүндрэлтэй, зохицуулах шаардлагатай асуудал их байдгийг уламжилж өгөхийг хүсч байв.
- Сумын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга нар нь ИНХ-ын дарга нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг. Гэтэл ихэнх сумын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга нь Ажлын албаны цорын ганц орон тооны ажилтан байдаг бөгөөд хуралдааны хэлэлцэх асуудлыг бэлтгэх, дарга тэргүүлэгчдийг мэдээллээр хангах, туслалцаа үзүүлэх, дотоод бичиг хэрэг хөтлөх гэх мэт олон ажлын хажуугаар багийн ИНХ-ын дарга нартай хамтран ажилладаг нь ажлын ачааллыг нь нэмэгдүүлдэг гэж харагдсан.

ИНХ-ын даргын 30%-ийн урамшууллаа чамлаж байгаа ч хүн байгаа, чамлахгүй ажиллаж байгаа ч хүн байгаа. БИНХ-ын дарга нар ажиллах орчин байр сав байхгүй, олон жилийн тогтолцоогоор явчихсан- иргэд зөвхөн багийн даргатай л харьцдаг. Багийн Засаг дарга маань БИНХ-ын дарга яг юу хийдэг, иргэдийн юуг шийдвэрлэж өгөх ёстой юм, яаж уламжлах ёстой вэ гэдгээ мэдэхгүй байгаа юм. БИНХ-ын дарга нарыг орон тооны болговол бид арай эрч хүчтэйгээр ажиллана.

*Дундговь аймгийн Эрдэнэцагаан сумын Ариунжиг буюу 5-р багийн БИНХ-ын дарга*

### ➤ ИТХ-ын Төлөөлөгчдийн манлайлын сургалт

*Орон нутгийн сонгууль төлөөлөгчдийн манлайллын сургалтыг боловсронгуй болгох:*

Орон нутгийн сонгуульд төлөөлөгчдөд зориулсан манлайллын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс олон улсын зөвлөх үйлчилгээ зарласны дагуу Их Британийн Нутгийн удирдлагын холбооны мэргэжилтэн Мари Дэвис 2016 онд монголд ажилласан. Энэ хугацаанд нийслэл, дүүрэг, аймаг, сумдын төлөөлөгчидтэй уулзаж манлайллын сургалтын хөтөлбөр, агуулга ямар байх хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны үндсэн дээр сургалтын хөтөлбөр боловсруулсан бөгөөд эхний ээлжинд Удирдлагын Академи, нутгийн удирдлагын ТББ-ууд, аймгийн ИТХ-ын сургагч багш нарын бүрэлдэхүүнээс 25 сургагч багш нарыг бэлтгэсэн. Зөвлөх багш Мари Дэвис 2017 оны 5 дугаар сард

манай улсад дахин ирж, манлайллын үндэсний сургагч багш нарт давтан сургалт явуулав.



Олон улсын зөвлөхийн бэлтгэсэн тус сургалтын агуулгад үндэслэн үндэсний сургагч багш нараас бүрдсэн ажлын хэсэг өөрийн улсын онцлогт тааруулан, манлайллын орчин үеийн онол, хандлагад суурилсан сургалтын шинэ агуулгыг ИТХ-ын төлөөлөгчдөд тусгайлан зориулж боловсруулав.

Улс төрийн манлайллын орчин үеийн онол, арга зүйд суурилсан энэхүү сургалт нь сонгогдсон төлөөлөгчийн нийгмийн хүсэн хүлээж байгаа өөрчлөлтийг хийх, уг хүсэл эрмэлзлээ бусдад ойлгуулах, нөлөөлөх чадваруудыг хөгжүүлэх зорилготой.

“Төлөөлөгчийн манлайлал” сургалт нь улс төрийн манлайлал, хувийн манлайлал, стратегийн манлайлал, иргэдийг манлайлах гэсэн дөрвөн үндсэн сэдвээс бүрдсэн хоёр өдрийн сургалт юм. Энэ сургалтын хөтөлбөрөөс Төлөөлөгчид өнгөрсөн үеийн сорилт, ололтоосоо үнэт зүйлээ тодруулж, алсын хараагаа тодорхойлох, өөрийн зорилго, ажил үйлсийг бусдад ойлгуулах, тэдний дэмжлэгийг авахын тулд манлайллын цогц түүх бүтээх, ярих, орон нутагт тулгамдаж буй асуудлыг томоор буюу бүтэн зургаар харж, цогцоор шийдэх зэрэг манлайллын орчин үеийн шинэлэг онол хандлагад үйлдэн суралцах буюу интерактив аргаар суралцдаг.

#### *ИТХ-ын дарга, тэргүүлэгчдэд манлайллын сургалт зохион байгуулах:*

Их Британийн Нутгийн удирдлагын холбооны мэргэжилтэн Мари Дэвис 2017 оны 5 дугаар сард монголд ажиллах хугацаандаа аймгийн ИТХ-ын дарга нар, орон нутгийн сургагч багш нар, зарим дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдэд сургалт явуулсан бөгөөд эдгээр сургалтад манлайллын гарын авлагыг боловсруулсан үндэсний 6 сургагч багш хамтран ажиллаж, онолын мэдлэгээ бататгахын зэрэгцээ сургалтын арга зүйн онцлогт суралцаж, дадлага хийв.

Сургалтад хамрагдсан аймгийн ИТХ-ын дарга нар, дүүргийн ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчид сургалтын хэрэгцээ шаардлага, зохион байгуулалтын талаар эерэг үнэлгээ өгсөн бөгөөд “бид харилцан бие биенээс их зүйлийг сурлаа, энэ сургалт өвөрмөц байлаа”, “сайхан ирээдүйг бүтээхийн тулд бид өмнөх түүхэн

үнэт зүйлээ мэдэх нь чухал юм байна”, “аймаг бүр өөрийн бэрхшээлтэй боловч бид бүгдийн хувьд нийтлэг оршиж буй бэрхшээлийг олж тодорхойллоо”, “аймгийн ИТХ-ууд УИХ, Засгийн газартай ойр харилцаатай байх нь чухал”, “манлайлал гэдэг иргэдтэй ойр байж, тэднийг сонсохыг хэлдэг болохыг ойлгож мэдлээ” зэрэг санал дүгнэлт хэлжээ. Сургалтад оролцсон аймгийн ИТХ-ын дарга нар ЗЗНДТУХ болон орон нутгийн эрх ашиг, сонирхлыг хөндсөн хууль, шийдвэрийг өөрчлөхөд орон нутаг дуу хоолойгоо хүргэх хэрэгцээ шаардлага байгааг онцолж, ийм бололцоог бий болгож өгөхийг төслөөс хүсч байв.



“ИТХ-ын Төлөөлөгчийн манлайлал сургалт” 2017 оны 5 дугаар сар

Хүснэгт 10

“Төлөөлөгчийн манлайлал” сургалт -2017 он				
№	Сургагч багш	Огноо	Оролцогчид	Оролцогчдын тоо
1	<b>Олон улсын зөвлөх Мари Дэвис</b>	2017.05.22-23	21 аймгийн ИТХ-ын дарга	21
2		2017.05.24	Үндэсний сургагч багш нар	6
3		2017.05.25-26	Дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчид	30
4		2017.05.29-30	Орон нутгийн сургагч багш нар	25
5	<b>Үндэсний сургагч багш нар</b>	2017.10.05-07	Орон нутгийн сургагч багш нар	25
6		2017.10.26-2017.11.17	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид	180
		2017.12.11-12	Сүхбаатар дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид	30

Өөрийн улсын онцлогт тааруулан шинэчлэн боловсруулсан Манлайллын хөтөлбөрийн дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн манлайллын сургалтыг 10-11 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгууллаа. Тус сургалтад үндэсний сургагч багш нарын хамт орон нутгаас бэлтгэгдсэн багш нар ажиллав.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн манлайллын сургалтыг 3 аймгийг нэг ээлж болгон нийт 7 ээлжээр зохион байгуулав. Нийт тэргүүлэгчдийн 80 хувь тус сургалтад хамрагдсан.

Хүснэгт 11

№	Аймаг	Огноо	Тэргүүлэгчдийн тоо	Сургалтад хамрагдсан Тэргүүлэгчийн тоо		
				Нийт	эрэгтэй	эмэгтэй
1	Архангай	2017.11.07-08	11	10	9	1
2	Баян-Өлгий	2017.10.26-27	11	11	9	2
3	Баянхонгор	2017.11.13-14	11	6	4	2
4	Булган	2017.11.09-10	11	11	9	2

5	Говь-Алтай	2017.11.13-14	11	10	9	1
6	Говьсүмбэр	2017.11.09-10	7	7	6	1
7	Дархан-Уул	2017.11.16-17	11	4	1	3
8	Дорноговь	2017.10.30-31	11	8	7	1
9	Дорнод	2017.11.07-08	11	6	4	2
10	Дундговь	2017.10.26-27	11	9	7	2
11	Завхан	2017.11.07-08	9	9	5	4
12	Орхон	2017.11.16-17	11	10	9	1
13	Өвөрхангай	2017.11.13-14	11	8	8	0
14	Өмнөговь	2017.10.30-31	11	9	9	0
15	Сүхбаатар	2017.11.02-03	11	11	9	2
16	Сэлэнгэ	2017.11.16-17	11	9	7	2
17	Төв	2017.11.02-03	11	6	3	3
18	Увс	2017.10.26-27	11	11	10	1
19	Ховд	2017.10.30-31	11	9	7	2
20	Хөвсгөл	2017.11.09-10	11	9	9	0
21	Хэнтий	2017.11.02-03	11	7	5	2
	<b>Дүн:</b>		<b>225</b>	<b>180</b>	<b>146</b>	<b>34</b>



Сургалтын үеэр авсан үнэлгээний санал асуулгад 107 хүн буюу оролцогчдын 60 хувь нь оролцов. Санал асуулгад оролцогчид сургалтыг дараах байдлаар үнэлжээ:

Хүснэгт 12

	Маш сайн	Сайн	Дунд
Сургалтын зохион байгуулалт	74.8%	17.8%	7.5%
Сургагч багш нарын мэдлэг	75.7%	20.6%	3.7%
Сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоо	78.5%	14%	7.5%
Сургалтын хуваарийн дагуу, үр дүнтэй болсон	78.5%	16.8%	4.7%
Сургагч багш нар жишээ, кейс сайн ашигласан	71%	25.2%	2.8%

Сургалтад оролцогчдын ирц идэвх, харилцан туршлага солилцсон байдал:

Хүснэгт 13

	Маш сайн	Сайн	Дунд
Оролцогчдын ирц, идэвх	31.8%	46.7%	19.6%
Бусад оролцогчдоос харилцан туршлага солилцож, суралцсан	58.9%	37.4%	3.7%

Сургалтын хэрэгцээ, шаардлага:

- Сургалтын сэдвүүд нь ИТХ-ын Тэргүүлэгчид ажил албаа хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг мэдээллийг өгч чадсан гэж 89.7 хувь;
- Сургалтаас ажил үүргээ арай өөрөөр хэрэгжүүлж болох шинэлэг санаа олж авсан уу гэхэд маш их гэж 80.4 хувь;
- Сургалтын үр дүн миний хүлээлттэй бүрэн нийцсэн гэж 68.2%, ер нь нийцсэн гэж 27.1 хувь нь;
- Энэ сургалтыг бусад Тэргүүлэгчдэд санал болгоно гэж 83.2 хувь нь тус тус хариулсан байна.

Сургалтад орон нутгийн манлайллын сургагч багш нар хамтран ажилласан нь цаашид сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдэд сургалтыг хүргэхэд нь онолын мэдлэгээ бататгах, агуулгын заах арга зүйн онцлогийг ойлгон, хэрэглэж сурахад дадлага болсон.

*Энэхүү манлайллын хичээлийг заахаар сургагч багшаар бэлтгэгдсэн нь миний хувьд аливааг том зургаар нь харах, асуудлыг олон талаас нь шинжлэн судлах зэргийг илүү их онолын түвшинд олж мэдсэн.*

*Хэнтий аймгийн сургагч багш*

### ➤ **Үндэсний сургагч багш нарын сүлжээг дэмжих, хөгжүүлэх**

Үндэсний сургагч багш нарын сургалтыг энэ онд дөрвөн удаа зохион байгуулав.

*Хүснэгт 14*

№	Огноо	Сургалтын зорилго	Сургагч багшийн тоо
1	2017.03.30-04.01	ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтад хэрхэн ажилласнаа дүгнэх, заах арга зүйг дээшлүүлэх	62
2	2017.05.25-26	Манлайлын сургагч багш бэлтгэх	25
3	2017.10.05.-07	Манлайллын сургагч багшийн давтан сургалт	25
4	2017.10.09-11	Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын сургагч багшийг бэлтгэх	60

*ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтад хэрхэн ажилласнаа дүгнэх, заах арга зүйг дээшлүүлэх сургалт:*

Төслийн хүрээнд 21 аймгаас 42, нутгийн удирдлагын чиглэлээрх төрийн бус байгууллагуудаас 20, нийт 62 сургагч багш бэлтгэгдэж, ИТХ-ын төлөөлөгчдийн суурь сургалтад ажилласан. Сургагч багш нарын бүрэлдэхүүнд аймаг, дүүргийн ИТХТ-ийн ажлын албаны нарийн бичгийн дарга 15, ИТХ-ын төлөөлөгч 6, ИТХ-ын дарга 3 хүн байв. Сургагч багш нарын 51.6 хувь нь эрэгтэй, 48.4 хувь нь эмэгтэй бол насны хувьд 30-45 насныхан ихэнх хувийг эзэлж байна.


*Хүснэгт 15*

Хүйс		Нас			
Эрэгтэй	Эмэгтэй	30 хүртэл	31-40	41-50	50-иас дээш
51.6%	48.4%	6.5%	30.6%	27.4%	35.5%

Шинэчлэн боловсруулсан сургалтын агуулгаар сургагч багш нарыг бэлтгэх эхний сургалт 2016 оны 11 дүгээр сарын 7-11-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, хөтөлбөрийн 4 сэдвийг тухайлан боловсруулсан Удирдлагын Академийн багш нар сургалтад багшилсан.

Сургагч багш нарын хоёр дахь удаагийн сургалтыг Удирдлагын академитай хамтран 2017 оны 03 сарын 30-аас 04 сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулав. Энэ сургалтын гол зорилго нь 2016 оны 11-р сараас 2017 оны 3 сар хүртэл аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-уудын 8000 гаруй төлөөлөгчдийн сургалтад хэрхэн ажилласанаа дүгнэж, цаашид анхаарах асуудал, сургалтын зохион байгуулалт, арга зүй, сургалтын агуулгыг сайжруулах талаар хэлэлцсэн.

Сургагч багш нарын ихэнх нь 1-3 удаагийн сургалтад ажилласан бол 5-7 удаа ажилласан сургагч багш нар ч байна.



Төслийн болон сургалтын хяналт үнэлгээний дүнд үндэслэн сургагч багш нарын заах арга зүйг сайжруулах хэрэгцээ, шаардлагыг хангахаар Боловсрол судлалын хүрээлэнгийн багш, доктор У.Туяа “Насанд хүрэгчдийн сургалтыг удирдах нь” сэдвээр сургалт явуулсан. Мөн ШХА-ын төслүүдийн хамтын ажиллаганы хүрээнд “Ногоон алт-малын эрүүл мэнд” төсөл “Бэлчээр зохион байгуулалт, эрсдлийн менежментийг боловсронгуй болгох нь” сэдвээр танилцуулга хийв.



*Сургагч багш нарын сургалт. Удирдлагын академи. 2017.04.01*

### **Сургалтын хяналт-үнэлгээ**

Сургалт семинарт оролцсон сургагч багш нараас сургалтын өмнө өөрийгөө үнэлэх асуумж, сургалтын дараа үнэлгээний санал асуулга авсан. Сургалтын дараах санал асуулгад оролцогчид сургалтын үр дүнг цаг үеэ олсон, хэрэгцээ шаардлагад нийцсэн гэж үнэлсэн бөгөөд дараах саналуудыг нэмж бичсэн байна.

- Сургагч багш болохын хувьд цаашид ямар чадавх, арга зүйг эзэмших шаардлагатайг ойлгосон.
- Нэмэлт мэдээллүүд таалагдсан.
- Оролцоо хангасан, асуудлыг шийдвэрлэсэн, санал хүсэлт сонссон багаар ажилласан сургалт болсон.
- Багшийн хичээл заах арга зүй, үнэлэлт дүгнэлт, харилцан туршлага солилцох зэрэг маш их мэдлэг, мэдээлэл авсан.
- Сургагч багшийн хувьд дутагдаж байсан мэдээллүүдийг олж авсан, өмнөх сургалтын үед өөрийн гаргаж байсан алдаа, дутагдлаа цэгцэлж өгөхөд тусалсан.
- Насанд хүрэгчдийн суралцахуйг удирдах нь сэдвийн хэрэгцээ их байлаа.
- сургагч багшийн хувьд заах арга барилд үр дүнтэй саналууд гарсан.
- Өмнөх сургалтын алдаа оноо юу байв, түүнд тулгуурлаж дараагийн сургалтаа зохион байгуулах, алдаа дутагдал, сургагч багшийн заах арга зүй, оролцогчдыг идэвхжүүлэх шинэ санаанууд олж авсан.

Харин энэ удаагийн сургалтаас ямар шинэлэг санаа олж авсан бэ гэхэд:

- Бүлгийн ажлын арга зүй, сургалт, цаашдын сэдвийн агуулгыг сайжруулахад анхаарах зүйлийн талаар олон санаа авсан.
- Багшлах заах арга зүйн том баг-жигжиг баг аргатай танилцсан. Мөн тайлан бичихэд үр дүнд тулгуурласан тайлан бичих, түүнд анхаарч ажиллах талаар ойлгосон.
- Оролцоог хангах, багаар ажиллуулах аргачлал, үнэлгээний аргачлал, үр дүнд суурилсан үнэлгээ гэх мэт шинэ санаа олныг авсан.
- Сургалтын үйл ажиллагаа эмх цэгц, багш нарын зүгээс сонсогчдод өгч байгаа арга барилд суралцсан. Өнөөгийн сургалтын арга барилаа сайжруулах тал дээр санаа оноо авсан.
- Хичээлийн агуулгаа гол гол зангилаагаар нь хүргэх, сэдвээ өөрийн болгох, цагаа зөв зохицуулах, мэдээлэл сайн цуглуулах ёстой гэдгийг ойлгосон.
- Насанд хүрэгчдийн сургалтыг удирдан зохион байгуулах арга зүйлд суралцаж, сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүйг эзэмшлээ.
- Багаар ажиллуулах шинэ арга хэлбэрүүдийг харж, өөрийн болгож зохион байгуулах сэдэл тэмүүлэлтэй боллоо.
- Цаг баримтлах, мэдрэмжтэй байх талаар санаа авсан
- Бүх багш нар зөвхөн мэдлэг олгох бус ер нь төлөөлөгчдийн ХАНДЛАГЫГ өөрчлөн чиглүүлж өгөх ёстой гэсэн суурь ойлголтыг авсан.
- Сэдвийн төлөвлөгөөг чанартай, зүй зохистой хийх, хичээлийн цаг хуваарилалтыг сайжруулах нь чухал гэдгийг ойлгосон.
- Практик туршлагаас сургамжтай, анхаарах, зайлшгүй мэдэж байх зүйлсийг мэдэж авсан гэжээ.

*Сургалтын үр дүн, дүгнэлт, санал*

- Сургагч багш нарын заах арга зүйг сайжруулах хэрэгцээ шаардлагад нийцсэн.
- Сургагч багш нар холбогдох сэдвийн дагуу бүлэгт хуваагдаж, сургалтын агуулгыг боловсруулсан Удирдлагын академийн багш нарын чиглүүлгээр сургалтад ажилласан туршлагаа ярилцсан нь цаашид арга зүйгээ сайжруулах, бусдаасаа суралцах боломж олгосон.
- Сургагч багш нарын ихэнх нь ИТХ-ын ажлын албанд ажилладаг, энэ чиглэлээр мэргэшсэн хүмүүс болохын нь хувьд цаашид багийн ИНХ, ажлын

абаны ажилтнуудад шаардлагатай сургалтын сэдвийн хэрэгцээ шаардлагыг тэднээр тодорхойлуулсан.

- Аймгуудын хувьд өөрийн болон зэргэлдээ аймгуудаас сургагч багш нарыг сургалтдаа урьдаг бол нийслэлийн дүүргүүдийн хувьд зарим тохиолдолд багшийн хүрэлцээ хангалтгүй байсан. Иймээс дүүргийн ИТХ-ын ажлын албанаас сургагч багш бэлтгэх санал дүүргүүдээс гарч байв.

### Манлайллын сургагч багш нарын сургалт

Манлайллын сургалтын гарын авлагыг боловсруулсан үндэсний сурагч багш нарын багтай хамтран аймаг тус бүрээс болон нутгийн удирдлагын чиглэлээрх ТББ-аас манлайллын сургагч багш нарыг бэлтгэв.

Сургагч багш нарын 2 удаагийн сургалтаар Төлөөлөгчийн манлайллын хөтөлбөрийн агуулга, шинэ онолд суралцсаны дараа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн манлайллын сургалтад хамтрагч багшаар ажиллаж, бүлгээр ажиллуулах арга зүйг эзэмшсэн.

Хүснэгт 16

	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
<b>Үндсэн сургагч багш</b>	3	5	8
<b>Аймаг, ТББ-аас бэлтгээгдсэн сургагч багш</b>	16	13	29
			37

### Багийн ИНХ-ын дарга нарт зориулсан сургалтын сургагч багшийг бэлтгэх сургалт:

Энэ удаагийн сургалтыг багийн ИНХ-ын дарга нарын сургалтын агуулга, гарын авлага боловсруулсан ажлын хэсэг хөтлөн явуулсан. Сургагч багш нарт агуулгыг хүргэхийн зэрэгцээ заах арга зүйн сургалт оров. Сургалтад оролцсон сургагч багш нарын тал хувь нь эмэгтэй, 20 хувь нь 35 хүртэлх насны залуучууд байна.

Хүснэгт 17

Эрэгтэй	Эмэгтэй	35 хүртэл	35-аас дээш	ИТХ-ын дарга	ИТХ-ын төлөөлөгч	ИТХТ-ийн нарийн бичгийн дарга	Ажлын албаны ажилтан
30	30	12	48	2	3	15	14

### **Сургалтын хяналт үнэлгээ:**

Сургалтын төгсгөлд авсан үнэлгээний санал асуулгад оролцогчдын 80 хувь хамрагдсан. Энэ удаагийн сургалтаас сургагч багшид шаардлагатай мэдлэг, мэдээллийг олж авч чадсан гэж 87.5 хувь, сургагч багшийн хувьд хандлага өөрчлөгдсөн гэж 86.9 хувь нь хариулсан байна. Сургалтын ач холбогдлыг 16.7 хувь нь маш сайн, 80 хувь нь сайн, 12.5 хувь нь дунд гэж үнэлжээ.

Цаашид сургагч багш нарын нөөц бололцоог хэрхэн ашиглах боломжтой талаар дараах саналыг гаргасан байна:

- Сургагч багш нарын арга зүйг сайжруулж, тоог цөөлөх
- Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаар иргэдэд сургалт явуулах



- Судалгаа, шинжилгээний ажилд хамруулж байх
- Үндэсний хэмжээнд НӨУБ-ын лаборатори байгуулах суурийг бий болгох
- Бусад төсөл хөтөлбөртэй холбох
- Гадаад улсад туршлага судлуулах
- Ажлын албыг чадавхжуулахад хамтран ажиллах
- Илтгэл, эссе бичих гэх мэт уралдаан зарлах
- Бусад аймгуудын сургалтад ажиллуулж, туршлага солилцох

➤ **Эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагыг шинэчлэх**

Төслийн баримт бичигт сонгуульт албан тушаал хашиж буй эмэгтэйчүүд орон нутагтаа болон ИТХ-д манлайлж ажиллах, сонгуульд өрсөлдөх, орон нутагт тулгарч буй асуудалд нэгдсэн шийдэл олох, ИТХ-ын шийдвэрт нөлөөлөх чадварыг нь дээшлүүлэх, ИТХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхийн тулд манлайллын сургалтыг үргэлжлүүлнэ гэж заасан.

Төслийн өмнөх үе шатанд ИТХ-д сонгогдсон эмэгтэй төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулж, 2000 гаруй эмэгтэй төлөөлөгчид тус сургалтыг хүргэсэн байдаг. 2016 оны орон нутгийн сонгуулийн дүнд бүх шатны ИТХ-д сонгогдсон нийт 2164 эмэгтэй төлөөлөгчийн 59.8% нь анх удаагаа сонгогдсон шинэ төлөөлөгч байна. Иймд эдгээр төлөөлөгчдөд тус сургалтыг дахин явуулах хэрэгцээ шаардлага тавигдаж байгаа юм. Энэ үүднээс сургалтын агуулгыг шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, өмнө нь сургалтад хамрагдсан оролцогчдын саналд үндэслэн дахин боловсруулах ажлыг зохион байгуулж байна.

➤ **Төслийн үр дүнгийн тогтвортой байдлын төлөвлөгөө боловсруулах, ШХА-ын төслүүдтэй хамтран ажиллах үйл ажиллагаа**

Төслөөс бий болсон үр дүнг цаашид тогтвортой үргэлжлүүлэх буюу институтчлэх нь төслийн нэг үндсэн зорилго бөгөөд санхүүжүүлэгчийн суурь болзол юм. Иймд төсөл хэрэгжүүлэх нэгжээс төслийн үр дүнгийн тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөг тусгайлан боловсрууллаа. Төлөвлөгөө нь төслөөс бий болох тодорхой үр дүнг холбогдох байгууллагуудтай ярилцан зөвшилцөж, тэдгээр байгууллагын чиг үүрэгт албан ёсоор тусгуулахаар зорьж байна. Тухайлбал, сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг Удирдлагын академи, бүх шатны ИТХ-ын нэгдсэн портал [www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудсыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, хурлын үйл ажиллагаанд мөрдөх жишиг дүрэм, аргачлалыг ИТХ-ууд, хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх журам, аргачлалыг УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагааны хүрээнд институтчлэхээр санал болгож байгаа юм.

Энэ зорилгоор эхний алхмууд хийгдээд байна. Удирдлагын академитай 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдөр Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан бөгөөд санамж бичгийн дагуу ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах суурь сургалтын хөтөлбөр, менежментийг Удирдлагын академид үе шаттайгаар шилжүүлж, 2020 оноос хойш Академи бүрэн хариуцах юм. Энэ үүднээс Удирдлагын академи 2017 онд санамж бичгийн дагуу сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах эрэлт хэрэгцээг судалж, хоёр модулийн хүрээнд дөрвөн сэдэв боловсруулан туршлаа. Түүнчлэн Удирдлагын академи өөрийн төсөвт бүх сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар болон дүүргийн ИТХ-ын ахлах мэргэжилтнүүдийг сургах төсвийг тусган батлуулсан нь хурлыг чадавхжуулах шинэ үүрэг хариуцлагаа чухалчлан үзэж байгаагийн илрэл боллоо.

Мөн [www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудсыг ЗГХЭГ-ын Орон нутгийн удирдлага зохицуулалтын газар, Мэдээллийн технологийн хэлтэс 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авч, системийн ажиллагааг бүрэн хариуцан ажиллаж байна. ЗГХЭГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн холбогдох ажилтан 360 гаруй дэд хуудасны админуудад өдөр тутам тусламж, заавар өгч, хэрхэн сайжруулж, шинэчлэх талаар санал санаачилга гарган ажиллаж байгаа нь тус цахим хуудсыг цаашид тогтвортой байлгахад чухал хувь нэмэр болж байна.

Бусад төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах хүрээнд ШХА-ийн “Ногоон алт, малын эрүүл мэнд” төсөлтэй бэлчээрийн менежментийг сайжруулахад ИТХ-ын гүйцэтгэх үүргийг таниулах, хурлын үйл ажиллагаанд хэрэглэх дүрэм журмыг боловсруулах талаар ажиллалаа.

#### **ҮР ДҮН 4. СОНГОГДСОН ТӨЛӨӨЛӨГЧДӨД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ**

- **УИХ-ын Тамгын газрын ажилтнуудыг хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, төслийн үр нөлөөг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалыг хэрэглэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр гадаад улсад сургалтад хамруулан сургагч багшаар бэлтгэх, ажилтнуудад сургалт зохион байгуулах**

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) хамтран УИХ-ын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга болон Эрх зүйн шинжилгээний албаны 6 ахлах зөвлөхийг 2017 оны 06 дугаар сарын 04-12-ны өдрүүдэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-д сургалтад хамруулав. Сургалтад оролцогчид ХБНГУ-ын хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалыг хэрэглэдэг туршлагыг судлав.

Дээрх сэдвийн хүрээнд Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал арга, технологитой нарийвчлан танилцаж суралцлаа. Үүнд:

- хууль, эсхүл тогтоол заавал гаргах шаардлага байгаа эсэх, ямар зорилготой, зохицуулалтын ямар хувилбарууд байгаа, тэдгээр нь ямар үр дагавар, үр нөлөөтэй байгааг урьдчилан тооцож, харьцуулах, эерэг, сөрөг үр дагавар, тохиромжтой байдлыг тогтоох, хүчин төгөлдөр болж хэрэгжсэний дараа түүнд хэрхэн мониторинг үнэлгээг хийхийг урьдчилан тооцоолох ;
- зорилгод хэрхэн хүрэх практикт хэрэгжих боломж, ойлгомжтой байдал, хүлээн зөвшөөрөгдөх байдал, харилцан нөлөөлөл, зардал гэсэн шалгуураар үр нөлөөг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл заалтыг сонгон, тохиромжтой арга хэрэгслээр шалгаж, туршилт, шалгалтын үр дүнгийн системчилсэн үнэлгээ хэрхэн хийх;
- хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний гэсэн 3 үе шат үнэлгээ хийж хууль хэрэгжилтийн үр нөлөөг судлах, шалтгааныг тодруулах, шалгуур үзүүлэлт, үнэлгээний хүрээг тогтоох, хуулийн хэрэгжилтийн байх ёстой болон одоо байгаа байдлыг, мөн өмнөх болон дараах байдлыг, түүнчлэн хууль хүчин төгөлдөр болсноос хойшхи

нөхцөл байдлыг тоо баримттайгаар харьцуулан судлах, холбогдох байгууллагын тайлан болон бусад материал ашиглах, мэргэжилтэн, иргэдтэй ярилцлага хийх зэргээр мэдээлэл цуглуулах, хууль хэрэгжүүлснээр хүрэхээр төлөвлөсөн зорилго тэр хүрээндээ хэрэгжсэн эсэх, зардал-үр өгөөжийн харьцаа эерэг эсэх, зохицуулалтууд хүлээн зөвшөөрөгдсөн практикт хэрэгжих боломжтой эсэх, дагалдаж гарсан эерэг, сөрөг ямар үр дагаварууд байна гэдгийг үнэлж дүгнэх;

- хуулиар хүлээсэн үүрэг, гүйцэтгэх ажил үйлчилгээ, зарцуулах цаг хугацаа болон тоон өгөгдөхүүн гарах зардлыг хүний нөөц материаллаг болон бусад зардлын нийт дүнг тооцоолон гаргаж илэрхийлэх, хялбарчлах хувилбарыг нягталж үзэх, үр дүнг хянах байдлаар иргэн, хуулийн этгээд, төрд үүсэх захиргааны зардлыг тооцох, мөн мэдээлэх үүргийг орлох өөр хувилбар байгаа эсэх, давтамжийг бууруулж болох эсэх, мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх, бусад байгууллагаас уг тоо баримтыг авах боломжтой эсэх, мэдээлэл, тоо баримтыг электрон шуудангаар явуулж болох эсэхийг нягтлах талаар судаллаа.

Сургалтын үр дүнд хууль тогтоомж хийдэл, давхардал, зөрчилдөөнгүй батлагдахад УИХ-ын Тамгын газраас үзүүлэх мэргэжил арга зүйн туслалцаа, үйлчилгээ, дэмжлэгийн чанар, үр дүн, үр нөлөө сайжирна гэж үзэж байгаа юм. Өөрөөр хэлбэл ХБНГУ-ын хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал болон хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалыг хэрэглэдэг тэргүүн туршлагыг судласанаар судалснаар манай улс ямар түвшинд байгаа, цаашид юунд анхаарах талаар тодорхой ойлголттой болсноор, УИХ-ын Тамгын газрын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн, улам боловсронгуй болгож, эрх зүйн шинжилгээний чанар, арга зүйг улам сайжруулах юм.

Сургалтын хүрээнд оролцогчдын судалсан туршлага нь УИХ, Байнгын хороо, УИХ-ын Тамгын газар, намын бүлгийн ажлын албанд нэвтрүүлэх сайн туршлага болно. Сургалтад хамрагдагсад сургалтын мөрөөр дараах арга хэмжээг авахаар төлөвлөж байна.

- Хууль тогтоомжийн хуулийг нэг мөр сахин мөрдүүлэх, УИХ, Засгийн газрын түвшинд төслийн үр нөлөөг үнэлэх, холбогдох хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг тооцох, уг хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийж, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий албадын үйл ажиллагааг сайжруулах, чадавхижуулах.
- Хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоог тухайн төслийн бүх зүйл, заалтыг хамруулан хийдэг одоогийн практик нь цаг шаардсан, их хэмжээний цаас зарсан ажил болж, хэлбэрдэх хандлага гарч болзошгүй байгаад дүгнэлт хийх, харин анхаарал татсан, маргаантай, зардал өндөртэй байх зүйл, заалтыг сонгон, түүнд үр нөлөөний болон зардлын тооцоо хийдэг болох, энэ чиглэлээр холбогдох аргачлалд өөрчлөлт оруулах.
- Хууль хэлэлцэн, батлах шатанд Байнгын хорооноос дэд ажлын хэсэг байгуулж, ажиллуулдаг практикийг халах, намын бүлэг хууль тогтоолын төсөлд зарчмын зөрүүтэй саналаа гарган /үр дагаврыг тооцуулсан/ Байнгын хороонд оруулдаг тогтолцоонд аажмаар шилжих.
- Хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэдэн хувьд өөрчлөлт оруулах босгыг хуулиар тогтоох, уг хувь хэмжээнээс давсан өөрчлөлт орохоор бол төслийг буцаадаг байх, мөн Байнгын хороонд

хэлэлцэж эхлэхээс өмнө намын бүлгээр хэлэлцүүлж, буцаах боломжийг бүрдүүлэх.

- Засгийн газраас хийсэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог УИХ-ын гишүүдийн хүсэлтээр хянах хөндлөнгийн бүтцийг УИХ-д бий болгох. /Бундестаг өөртөө ийм бүтэц байгуулахыг зорьж байгаа./
  - Сургалтын хөтөлбөр боловсруулж, УИХ-ын гишүүн, түүний зөвлөх, туслах, Байнгын хороодын ажлын албаны ажилтнууд, УИХ дахь намын бүлгийн ажлын албаны ажилтнуудад сургалт зохион байгуулах.
- **УИХ-ын Тамгын газрын хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чадавхыг сайжруулах зорилгоор гадаад улсын туршлага судлах**

Швейцарийн Холбооны Улсын парламентын Тамгын газрын төлөөлөгчид манай улсад 2017 оны 11 сарын 27-оос 12 дугаар сарын 1-ний өдрүүдэд ажиллаж, хоёр орны парламентын хууль тогтоох, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр харилцан туршлага солилцов. Туршлага солилцох уулзалт семинарт ШХУ-ын талаас парламентын Тамгын газрын техникийн хамтын ажиллагааны төсөл, Байнгын хороо, Хяналт шалгалтын нэгжийн зөвлөх, ажилтнууд, манай улсаас УИХ-ын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Мэдээлэл, хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ажилтнууд оролцлоо.

Семинарт “Улс төрийн тогтолцоо, төрийн байгуулалт”, “Хоёр улсын парламентын бүтэц, зохион байгуулалт, бүрэн эрх” сэдвийн хүрээнд хоёр орны парламентын Тамгын газрын алба хаагчид илтгэл тавьж, харилцан сонирхсон асуултдаа харилт авч, мэдээлэл солилцсон.



Семинарын үеэр авсан санал асуулгад оролцсон УИХ-ын Тамгын газрын ажилтнууд харилцан ярилцаж, туршлага солилцсон, ач холбогдолтой уулзалт боллоо гэж дүгнэсэн байв. Ялангуяа парламентын хяналтын чиглэлээр ШХУ-ын туршлагаас их зүйл сонсож, мэдээлэл авсан гэв. Мөн ажил үүргээ гүйцэтгэхэд тус болох ямар шинэ санаа авсан, үүнийг хэрэгжүүлэхэд ямар дэмжлэг туслалцаа шаардлагатай байна вэ гэхэд:

- Парламентын бүтцэд Хяналтын хороо байгуулах нь хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой
- Тамгын газрын бүтцэд байгаа ХШҮ-ний нэгжийг Парламентын Хяналтын хорооны бүтцэд харьяалуулж, мэргэшсэн алба болгох
- ХШҮ-ний албаны ажилтнуудын судалгаа шинжилгээний арга зүйг сайжруулж тоон болон чанарын шинжилгээ, фокус ярилцлага хийх, хяналтын тайлан бичих чадвартай болгох

- Үнэлгээ хийхэд шаардлагатай дата баазыг бий болгох, үнэлгээний тусгай программыг нэвтрүүлэх
  - Швейцарийн парламентад газар дээр нь очиж судлах, ажилтнуудын хооронд холбоо тогтоох зэрэг санал хамгийн их дурдагдсан байв.
- **Холбогдох байнгын хорооноос хуулийн төслөөр нийтийн сонсгол зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх**

Төслийн хэрэгжилтийн эхний үе шатанд видео хурлын төхөөрөмжийг 21 аймагт суурилуулан хүлээлгэн өгсөн. Тус төхөөрөмжийг ашиглан 2017 онд олон нийтийн хэлэлцүүлэг хоёр удаа зохион байгуулагдав.

1. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хүрээнд УИХ-ын гишүүд, аймаг, нийслэлийн төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтнуудын оролцсон цахим хурал 07 дугаар сарын 18-ны өдөр болов. Цахим хуралд Төрийн байгуулалтын байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, нийслэлийн есөн дүүрэг, 21 аймаг, сумдын Засаг дарга, ИТХ-ын тэргүүлэгчид, УИХ-ын Тамгын газрын ажилтнууд оролцов.
2. УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Өргөдлийн байнгын хорооны 2016 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг сонсох тухай асуудлыг хэлэлцсэн. Тус цахим хуралдаанд 21 аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга, Тамгын газрын удирдлагууд оролцож тус Байнгын хорооны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.

- **УИХ-ын Тамгын газрын хууль тогтоох үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чадавхыг бэхжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх**

УИХ-ын хууль тогтоох ажиллагаанд Тамгын газрын зөвлөхийн баримтлах гарын авлагын төслийг Зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулж байна.

Хууль, эрх зүйн хэлтсийн зөвлөхүүдийн хуулийн төслийн эхийг барьж ажиллах чадавхыг сайжруулах чиглэлээр “Хуулийн төсөл боловсруулах, хууль тогтоох ажиллагаанд эрх зүйн туслалцаа үзүүлэх чадавхыг сайжруулах нь” сэдэвт сургалтыг 10 дугаар сарын 30-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулав. Хуулийн төслийн агуулга бүтээх буюу төсөл боловсруулах, хууль тогтоох ажиллагаанд хууль зүйн техникийг хэрэглэх онол, орчин үеийн чиг хандлага, батлагдсан хуулийн хэлний болон үг зүйн алдаа, тэдгээрийг засварлах зэрэг сэдвээр мэргэшсэн судлаачид сургалт явууллаа.

## **ДҮГНЭЛТ**

Төслийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хангалттай сайн хэрэгжиж байна. 2017 оны санхүүгийн гүйцэтгэл 92 хувьтай байна.

Төслийн баримт бичигт “төслийн хэрэгжилтийн байдалд мэргэжлийн дүгнэлт өгөх үүднээс НҮБХХ-ийн Бангкок дах бүсийн төвийн орон нутгийн засаглалын

зөвлөх хагас жил тутам ирж ажиллан, төслийн ерөнхий чиг хандлагын талаар төслийн холбогдох талуудтай зөвлөлдөж байна” гэж заасан. Үүний дагуу НҮБХХ-ийн Бангкок дах Бүсийн төвөөс зөвлөх Патрик Дуонг 2017 оны 6 дугаар сарын 5-9-ний өдрүүдэд ирж ажилласан бөгөөд төслийн хэрэгжилтийн явц сайн, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд хэвийн хэрэгжиж байна гэж дүгнэсэн.

Төслөөс бий болсон үр дүнг цаашид тогтвортой үргэлжлүүлэх буюу институтчлэх нь төслийн нэг үндсэн зорилго бөгөөд санхүүжүүлэгчийн суурь болзол юм. Иймд төсөл хэрэгжүүлэх нэгжээс төслийн үр дүнгийн тогтвортой байдлыг хангах төлөвлөгөөг тусгайлан боловсрууллаа. Төлөвлөгөө нь төслөөс бий болох тодорхой үр дүнг холбогдох байгууллагуудтай ярилцан зөвшилцөж, тэдгээр байгууллагын чиг үүрэгт албан ёсоор тусгуулахаар зорьж байна. Тухайлбал, сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг Удирдлагын академи, бүх шатны ИТХ-ын нэгдсэн портал [www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудсыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, хурлын үйл ажиллагаанд мөрдөх жишиг дүрэм, аргачлалыг ИТХ-ууд, хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх журам, аргачлалыг УИХ-ын Тамгын газрын үйл ажиллагааны хүрээнд институтчлэхээр санал болгож байгаа юм.

Төслийн хүрээнд бий болсон үр дүнг цаашид тогтвортой хадгалах, институтчлэх чиглэлд тодорхой ахиц гарлаа. Үүнд:

- Сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх байнгын механизмтай болох зорилтын хүрээнд Удирдлагын академитай 7 дугаар сарын 18-ны өдөр Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав. Санамж бичгийн дагуу ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах суурь сургалтын хөтөлбөр, менежментийг Удирдлагын академид үе шаттайгаар шилжүүлж, 2020 оноос хойш академи бүрэн хариуцна. Энэ үүднээс Удирдлагын академи 2017 онд санамж бичгийн дагуу сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах эрэлт хэрэгцээг судалж, хоёр модулийн хүрээнд дөрвөн сэдэв боловсруулан туршлаа. Түүнчлэн Удирдлагын академи өөрийн төсөвт бүх сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар болон дүүргийн ИТХ-ын ахлах мэргэжилтнүүдийг сургах төсвийг тусган батлуулсан нь хурлыг чадавхжуулах шинэ үүрэг хариуцлагаа чухалчлан үзэж байгаагийн илрэл боллоо.
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар бүх шатны ИТХ-ын нэгдсэн портал [www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудсыг ЗГХЭГ-ын Орон нутгийн удирдлага зохицуулалтын газар, Мэдээллийн технологийн хэлтэс 5 дугаар сарын 10-нд хүлээн авч, системийн ажиллагааг бүрэн хариуцаж байна. ЗГХЭГ-ын Мэдээллийн технологийн хэлтсийн холбогдох ажилтан 360 гаруй дэд хуудасны админуудад өдөр тутам тусламж, заавар өгч, хэрхэн сайжруулж, шинэчлэх талаар санал санаачилга гарган ажиллаж байгаа нь тус цахим хуудсыг цаашид тогтвортой байлгахад чухал хувь нэмэр болж байна.
- УИХ-ын Тамгын газар, Швейцарийн Холбооны Улсын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны эхлэлийг тавьж, хуулийн төсөлтэй ажиллах, хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр аргачлал, гарын авлага хамтран боловсруулж, эдгээр үйл ажиллагаанд шинэ жишиг тогтоохоор боллоо.
- ИТХ-ыг чадавхжуулахдаа өөр бусад байгууллага, төслийн хүрээнд байгаа боломж бололцоо, мэдээлэлтэй холбож өгөхийг зорьж ажиллаж байна. Тухайлбал ТББ-уудад байгаа төсөв, байгаль орчны холбогдолтой мэдээлэл,

сургалт, сайн туршлага, ШХА-ийн “Ногоон алт, малын эрүүл мэнд” төслийн хүрээнд бий болсон бэлчээрийн нөхцөл байдлын талаарх мэдээллийн сан, орон нутагт хамтран ажиллах боломжтой талууд, үйл ажиллагаандаа хэрэглэж болох журам, аргачлал, бэлчээр ашиглалтын гэрээний загвар гм мэдээллийг ИТХ-уудад хүргэх, хамтын ажиллагааг дэмжихэд анхаарч ажиллалаа.

УИХ-ын Тамгын газрын удирдлага, холбогдох ажилтнууд зөвлөмж чиглэл өгөх, сургалт, хэлэлцүүлэг, зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад оролцох зэргээр идэвхтэй ажиллаж байгаа нь төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж, УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 217 тоот захирамжийн дагуу төсөв, гүйцэтгэл, худалдан авалт зэрэг 19 нэр төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтмол оруулж байна.

Үндэсний хэмжээнд зохион байгуулсан сургалтууд, тэтгэлэгт хөтөлбөр, сэдэвчилсэн хэлэлцүүлгээс гарсан санал, санхүүжүүлэгч байгууллагын хийсэн мониторингийн санал, зөвлөмжийг 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаад байна. Тухайлбал, ИТХ-ын ажлын албыг чадавхжуулах, гурван шатны хурлын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах, энэ зорилгын үүднээс төслийн хүрээнд бэлтгэгдэж, туршлагажсан сургагч багш нар, ТББ-уудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зэргийг онцолж болох байна.

-оОо-